2. Улсын их дэлгүүрт юу ч бий. Энэ шүүгээнд юу ч алга. Би юуны ч сүү ууж чадна. Энэ үдэшлэг юунд ч зориулагдсан юм биш. Би энэ тухай юу ч сонсоогүй. Байшинг юугаар ч барьж болно. Энэ зураг юутай ч адилгүй болжээ.

3. Ийм газар ямар ч улсад бий. Аль ч хэлийг сурахад ном их унших хэрэгтэй. Тэр номыг энэ хоёрын алинд ч битгий өг! Надад

ийм ном хэд ч байна. Та түүнээс хичнээнийг ч авч болно. Та манайд хэзээ ч ирж болно. Би хэдийд ч тамхи татдаггүй. Би яаж ч чадна. Та ийм үзэг хаанаас ч олохгүй.

4. Чи аль нэг газар ангийнхныхаа хэн нэгтэй уулзвал миний энд байгааг хэлээрэй. Надад хэзээ нэг цагт ямар нэгэн сайн морь олдоосой. Та хаа нэг(н) газар ийм хүн үзсэн үү? Чи энэ олон гутлынхаа аль нэгийг дүүдээ өгөөч! Танд ямар нэг асуулт байвал тэр хүнээс асууж болно.

**Усилительные частицы  
пишутся после слов:**

*л* — именно, только это

*ч* — и это, также, ...и ...и, ни... ни...

*ч гэсэн* — хотя

**Дасгал 7.** Переведите с монгольского языка на русский:

1. Би л энэ туужийг уншаагүй. Би энэ туужийг л уншаагүй. 2. Би ч энэ туужийг уншаагүй. Би энэ туужийг ч уншаагүй. 3. Нацагдорж л монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч мөн. Д. Нацагдорж ч монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч мөн. 4. Ангид Дорж л байсангүй. Ангид Дорж ч байсангүй. 5. Дулмаа ч надтай уулзаагүй. Дулмаа л надтай уулзаагүй. 6. Дулмаа надтай ч уулзаагүй. Дулмаа надтай л уулзаагүй.

**Дасгал 8.** Переведите с русского языка на монгольский:

1. Когда друг приехал, я его не встречал и когда уезжал, не провожал. 2. Здесь есть и молоко, и тараг. 3. Он был и в Японии, и в Китае. 4. Учитель завтра и тебя спросит, и меня (спросит). 5. Тот ребенок и не плакал и не смеялся. 6. Эти ботинки хоть и дорогие, зато хорошие. 7. В классе только учитель. 8. Только с тобой я встречусь. 9. Именно сегодня он придет. 10. В Монголию я летаю всегда только самолетом. 11 В Японию можно поехать и самолетом и пароходом.

**Дасгал 9.** Переведите с монгольского языка на русский:

1. Доржийн шалгалт нь хэзээ эхлэх бол? Чи мэдэв үү? 2. Бат намайг өчигдөр өглөө ирнэ гэж хүлээгээ бол уу? яагаа бол?



Өөрөөс нь асууя... Бат аа, чи намайг өчигдөр өглөө ирнэ гэж хүлээв үү, яав? 3. Ангид хэдэн оюутан байгаа бол? Очиж үзье. 4. Намайг одоо буцаад очвол ээж гайхах бол уу? 5. Ах өнөөдөр чоно алсан бол уу? Хэрэв алсан бол хэдийг алсан бол? 6. Би тэр хүүхнийг чухам юу эрж байгаа юм бол? гэж бодоод» «Та юу эрж байгаа юм бэ?» гэж асуувал тэр ичээд юу ч хэлсэнгүй. 7. Бат түүнийг хараад «Энэ үнэг үхсэн юм бол уу?» гэж бодсоор түүнд ойртлоо. 8. Та тийшээ хэзээ явах бол? Би танаар дүүдээ нэг ном явуулмаар байна. 9. Сургууль дээр очвол Дулмаатай дайралдах бол уу? 10. Хүү минь одоо хаа яваа бол? Даарч яваа бол уу?

**Дасгал 10.** Допишите диалог:

А. Найз аа, чи энд юу хийж байгаа юм бэ?

Б. . . . .

А. Удаан хүлээж байна уу? Хаа хүрэх нь вэ?

Б. . . . .

А. Тэгвэл хамт явъя. Би бас тийшээ явж байна. Миний нэг танил залуу тэнд сурдаг юм. Түүнтэйгээ очиж уулзахаар явж байна.

Б. . . . .

**Дасгал 11.** Составьте предложения со следующими словосочетаниями:

санаанд тохирох, сайхан санагдах, муу санагдах, хийх санаатай, гэрээ (нутгаа) санах, дуртай хоол, зохих, аятайхан болох, удаан хүлээх.

**Дасгал 12.** Перепишите весь диалог по-монгольски:

А. Чи над монголын түүхийн сурах бичгээ өгөөч. Би уншаад өгье.

Б. Ты ведь (возьмешь) ненадолго?

А. Хаанаас даа! Би нөгөөдөр л өгнө.

Б. Ну, тогда возьми. Я сюда не принес. Пойди к нам и возьми. Но только смотри, послезавтра не забудь (уузаЙ) отдать!

А. Хорошо. Когда придти и взять?

Б. Хэдийд ч яахав. Би одоо хариад хаашаа ч явахгүй. Гэртээ л байна. Өнөөдөр ангид давтлага байхгүй.

- А. Ты к экзаменам готовишься?  
 Б. Конечно! Послезавтра у меня экзамен по литературе. Сейчас ничего не знаю.

**Дасгал 13.** Переведите с монгольского языка на русский и запомните разговорные выражения:

Тэгэлгүй яахав! Ярилгүй яахав! Бололгүй яахав! Тэгсэн ч болно. Яагаад гэвэл... Тэгэхлээр...

### Хоолны газар\*

Манай сургуулийн нэгдүгээр давхарт сайхан гуанз бий. Найз бид хоёр өдөрт гурван удаа тэр гуанзанд очиж хоолонд ордог.

Өглөө найман цагт би хар цай, сүү, цагаан талх, шарсан өндөг иддэг. Өчигдөр хичээлийн дараа бид сургуулийн хоолны газарт очлоо.

- үдийн хоолонд чи юу авах вэ?
- Би улаан шөл, хуушуур, шарсан мах, хонины мах, талх, сүүтэй цай авна.
- Би гурилтай шөл идмээр байна.
- Чи монголын үндэсний хоол идэж үзсэн үү?
- Үзээгүй. Харин бууз их амттай шүү.
- Чи хуушуур, бууз, бяслаг, ааруул, махны хуурга аваарай.
- За, тэгье.
- Өнөө орой хоёулаа ресторанд очих уу?
- Очно. Чамд мөнгө бий юу?
- Байна, байна. Ресторанд айраг уух уу? Би урьд өмнө айраг уугаагүй.
- Пиво, хиам, жүрж, мөхөөлдөс, жимс, ногоо авъя.
- За, хоёрдугаар хоол болсон уу?
- Болоогүй. Жаахан хүлээ.
- За, хүлээж болно. Одоо хөгжим сонсож сууя.
- Энд тамхи татаж болохгүй.
- Сайхан хоол идлээ. Цадлаа. Одоо явъя. Найз минь, баяртай!
- Маргааш гурван цагийн хичээлтэй биз. Бас гэрийн даалгавраа хийх хэрэгтэй.

## ЯРИАНУУД\*

### Гуанзанд

- Энд хүнтэй юу? — Хүнтэй.  
— Энд хүнтэй юу? — Хүнгүй.  
— Энд сууж болох уу? — Болно.
- \* \* \*
- Хоолны цэс хаа байна? — Энд байна. Та юу авах вэ?  
— Ногоотой шөл, шарсан мах авъя. — Уух юм авах уу?  
— Нэг сүүтэй цай авъя. Жимсний — Бий.  
ус бий юу?  
— За, нэг аяга жимсний ус авъя.  
— Үйлчлэгч ээ, мөнгөө аваарай!  
— Хэдэн төгрөг болж байна вэ? — Дөрвөн төгрөг 50  
— Баяртай. мөнгө.

### Цаг засварт

- Сайн байна уу? Энд цаг засдаг уу?  
— Тиймээ, та цаг засуулах нь уу?  
— Миний цаг ойрдоо буруу яваад болохгүй байна. Газар унагачихсан чинь шил нь бас хагарчихаж.  
— (Цагчин цагийг нь авч нилээд үзээд). Шил хагарсан учраас зүүгээ саатуулж байгаа юм байна. Хэрвээ та засуулъя гэвэл энэ бичгийг кассанд өгөөд мөнгөө хураалгаад тасалбар аваад ирээрэй.  
— За, энэ тасалбар авахгүй юу?  
— Та нэг тасалбарыг нь өөрөө ав.  
— Хэдийд гарах вэ?  
— Нөгөөдөр хэдэн цагт ч болно.

### Цагчинд

- Та миний цагийг үзээд өгөхгүй юу?  
— (Цагчин цагийг задлаж нилээд үзээд):  
— Гол нь хугарсан байна.  
— Тэгвэл засаж болохгүй юу?  
— Болно, болно. Голыг нь солих хэрэгтэй дээ. Кассанд бичүүлээд ирээрэй.

- (Кассанд очиж мөнгөө тушаагаад). — За, энэ бичиг нь байна.  
Хэзээ авч болох вэ?  
— Хоёр хоноод ирж аваарай.

### *Хувцасны захиалга*

- Хувцас захиалгын газар хаана байдаг юм бэ?  
— «Урт цагааны» тэнд байдаг. Чухам юу захиалах гэсэн юм бэ?  
— Би савхин цамц хийлгэмээр байна. Сайхан даавуу байвал костюм ч захиалах санаатай.

### *Хувцас захиалгын газарт*

- Сайн байна уу? Савхин цамц захиалах гэсэн юм.  
— Тэгвэл тэр байгаа савхинаас сонгоорой.  
— Би энэ хүрэн савхиар хийлгэе.  
— Та кассанд мөнгөө тушаагаад хэмжээ авхуулаарай.  
— Үйлчлэгч ээ, би урьдчилгаа болгож хоёр зуун төгрөг тушаая.  
— За, энэ тасалбар аваарай.  
— Та миний хэмжээ авахгүй юу?  
— Тэгье, эхлээд цээжний өргөн, ханцуйн хэмжээ авъя. Уртхан хийлгэх үү?  
— Үгүй ээ, богиновтор (бас) зах нь дөрвөлжин байвал сайн. Талдаа 4 товчтой хийлгэе.  
— Болно оо.

### *Зурагчин*

- Та зургаа хаана авхуулсан бэ?  
— Би энэ зургийг өнгөт зурагчинд авхуулсан юм. Ямар гарсан байна?  
— Сайхан гарсан байна. Өнгөт зурагчин хаана байдаг юм бэ?  
— Би та хоёрт зааж өгье. Гурвуулаа хамт явъя.  
— Бид хоёр өнгөт зураг авхуулмаар байна. Эндээс хол уу?  
— Холгүй ээ, их сургуулийн хажуу талд байдаг юм.

\* \* \*

- Түргэн зурагчин хаана байдгийг та надад зааж өгнө үү?  
— Та «Урт цагааныг» мэдэх үү?  
— Мэднэ.  
— Тэгвэл «Урт цагааны» урд талд байдаг юм.  
— Сайн байна уу? Би зургаа яаралтай авхуулах гэсэн юм.

- Та ямар зураг авхуулах вэ?
- (Би) паспортын зураг авхуулмаар байна. Ямар үнэтэй вэ?
- 5 төгрөг 50 мөнгөний үнэтэй. За, та ингэж суугаад над руу хараарай! Анхаараарай! Дарлаа шүү! Боллоо.
- Зурагчин гуай, зургаа хэдийд ирж авах вэ?
- Гучин минутын дараа ирээд аваарай.

Дасгал 14. Задания:

1. Пригласите друга пообедать.
2. Спросите, занято ли место.
3. Скажите, что вам нужно сфотографироваться. Спросите, сколько стоит цветная фотография.
4. Спросите, где находится часовая мастерская.
5. закажите себе сшить кожаное пальто.
6. Попросите поставить набойки на туфли.

## ХЯНАЛТЫН АЖИЛ

*Повторительные предложения:*

-х гэтэл; -х тутам; зөвхөн төдийгүй; -х байх; -ж магадгүй; усилительные частицы: л, ч ..., -аасай, -г, бол уу.

1. Что-нибудь скажи. 2. Я хотел говорить дальше, но мне не дали. 3. Я хотел купить книгу, но у меня не было денег. 4. Я хотел написать письмо, но ручку не нашел. 5. Мы хотели поехать в центр, но не нашли машину. 6. Я хотел принести газет, но в киоске их не было. 7. Наверное, он пришел. 8. Может быть, он пришел. 9. Может быть он пришел? 10. Интересно, завтра будет дождь?

\* \* \*

1. Говорите громче! Пусть они послушают! 2. Не шумите, плохо слышно. 3. Пусть младший брат повторяет уроки. 4. Не забывайте свои вещи! 5. Хорошо бы снова вышел этот фильм. 6. Хорошо бы у меня была машина. 7. Дорж говорит по-русски лучше, чем Бат. 8. Интересно, где он сейчас работает? 9. Что-то сейчас делает мой отец? 10. На улице нет ни ветра, ни дождя. 11. Такие предприятия есть в любой стране. 12. Можно и так. 13. Так нельзя делать. Так нельзя говорить.

14. Можно подумать. Можно сказать? Можно спросить?  
 15. Если так, я пойду. Все равно я пойду. Все равно я не пойду.  
 16. Позовите кого-нибудь из них. 17. Я знаком только с Батом. 18. Именно сегодня он придет. 19. Это может приготовить любой человек. 20. Эту книгу нигде не достать. 21. Вы всегда можете к нам прийти (в любое время). 22. Я все могу. Я ничего не могу. 23. Нет ни одного лишнего билета. 24. Эти ботинки дорогие, зато хорошие. 25. Пусть и поздно, я читаю газеты каждый день.

## Үг хэллэг

### Хоолны газар

<b>бууз</b> бозы	<b>хургатай хоол</b> мелко нарезанная молодая баранина с гарниром
<b>банш</b> пельмени	<b>байцаатай хурга</b> баранина с капустой
<b>аарул</b> сушеный творог	<b>аршаан</b> минеральная вода
<b>айраг</b> кумыс	<b>мөхөөлдөс (зайдас)</b> мороженое
<b>бяслаг</b> сыр	<b>хоол болох</b> блюдо готово
<b>тараг</b> кефир, кислое молоко	<b>мах татах</b> очень мелко резать мясо для боз
<b>хуушуур</b> род чебуреков	<b>шарсан мах</b> жареное мясо
<b>шөл</b> бульон	<b>чанах</b> варить
<b>байцаа</b> капуста	<b>өлсөх</b> проголодаться
<b>нухаш</b> паштет	<b>цадах</b> насытиться
<b>архи</b> водка	<b>ам цангах</b> мучает жажда
<b>улаан шөл</b> борщ	<b>хэрчих</b> резать хлеб
<b>өндөг</b> яйцо	<b>өөрөө үйлчлэх</b> самообслуживание
<b>хнам</b> колбаса	<b>зөөгч</b> официант
<b>талх</b> хлеб	<b>хоолны цэс</b> меню
<b>цагаан будаа</b> рис	<b>лонх, шил</b> бутылка
<b>жүрж</b> лимонад	<b>хундага</b> бокал, рюмка
<b>жимс</b> фрукты	<b>янжуур тамхи</b> сигареты
<b>гурилтай шөл</b> суп-лапша	<b>жигнэх, хайрах</b> печь
<b>гурил</b> мука	<b>амсах</b> пробовать;
<b>хуйцаа</b> ассорти (кит. мясное блюдо)	
<b>байцаатай шөл</b> щи с капустой	
<b>хар шөл</b> простой бульон с большим количеством мелко нарезанной баранины	

амттай вкусный  
гуанз столовая  
хүнтэй занято;  
хүнгүй свободно (место)  
хүнсний дэлгүүр продоволь-  
ственный магазин  
ХИД хүнсний их дэлгүүр  
буцалсан ус кипяченая вода  
үсчин парикмахер  
хувцасны өлгүүр вешалка  
багасгах укоротить  
тайруулах подстричь  
өтгөн үстэй густые волосы  
сахал борода, усы  
хууз бакенбарды  
шингэлэх проредить волосы  
хусуулах побриться  
тослуулах сбрызнуть волосы  
цаг засвар часовая мастерская  
хагарах разбиться  
унагах уронить

гол ось  
кассанд бичүүлэх (тушаах) зап-  
латить в кассу, выписать  
чек  
хувцас захиалга пошивочное  
ателье  
савхин цамц (хийлгэх) кожа-  
ная куртка (сшить по зака-  
зу)  
нэхий дээл дубленка  
захиалга заказ, заявка  
зурагчин фотограф  
зураг авах фотографировать  
зураг авхуулах сфотографи-  
роваться  
мөнгөө хураалгах заплатить  
деньги  
тасалбар чек, квитанция  
мөнгө тушаах, хураалгах  
сдать деньги

## ЦАГААН САР — БЕЛЫЙ МЕСЯЦ ИЛИ НОВЫЙ ГОД ПО-МОНГОЛЬСКИ

Цагаан сар (белый месяц) отмечается в январе или феврале по лунному календарю. Это тройной праздник — наступление Нового года, общий день рождения и праздник благополучной перезимовки скота, начало весны.

К Цаган сару готовятся задолго до его начала. Основные блюда праздничного стола: бозы **бууз** (круглые пельмени с мелко нарубленным мясом на пару), **банш** — пельмени, **боов** — печатные пряники овальной формы, **еэвэн** — круглый корж с узором. Приготовленные бууз замораживают, а специально хранящиеся с осени молоко и кумыс размораживают.

День накануне Цаган сара, своеобразный «сочельник» называется **битүүн**. В этот день варят баранину, желательна всю

тушу целиком. Рацион молочной пищи монголов составляет более двадцати видов. Праздничная трапеза начинается после захода солнца. В центре стола водружается вареный крестец. Ставят его таким образом, чтобы баранья голова, поставленная на крестец, была повернута к хоймору, куда усаживается хозяин дома и почетные гости, а курдюк в сторону входа. Трапезу всегда начинают с чая.

Встречают Новый год (**сар шинийн нэгэн**) с первыми лучами солнца. Обряд поздравления или приветствия **золгох** начинают с самых старших в семье. Приветствуя старшего, молодые протягивают к нему руки ладонями вверх, старшие кладут свои руки сверху ладонями вниз. Строго соблюдается требование, чтобы одежда была в порядке — пуговицы застегнуты, края шапок подняты, пояс ровно и туго затянут, рукава **дэли** отвернуты.



Наиболее почитаемым во время **Цаган сара** считается белый цвет. Раньше старались надевать белые одежды. В знак уважения хозяину дома подносят голубой **хадак** и подарки (часто молодые дарят старикам денежные купюры). В ответ каждый гость, в том числе и все дети, получают от хозяев подарки. Считается, что подарок должен состоять из двух вещей, причем одна из них плоской формы и белого цвета, например, платок, салфетка и т. д.



## СТРАНА ВЕЧНО СИНЕГО НЕБА

## ГРАММАТИКА

I. Способы выражения причинно-следственных отношений в предложении:

1. *Союзы*: учир, учраас, тул, улмаас, болохоор. Например:  
Тэдний олонхи нь эмэгтэйчүүд учраас Даваасүрэн гэдэг хүнийг олж чадсангүй.

Так как многие из них были женщины, не смог отыскать человека по имени Даваасурэн.

Содов гуай хувийн машинаар ирсэн тул Намнанг гэрт нь хүргэж өгсөн.

Так как Содов гуай приехал на своей машине, отвез Намнана домой.

Зун цаг байсан болохоор тэдний шон дээр морь олон.

— Так как время было летнее, на их привязи было много лошадей.

Худалдааны гадаад харилцааны яам байгуулсны улмаас гадаад эдийн засгийн үр ашиг дээшилж байна.

Благодаря организации министерства внешней торговли эффективность внешнеэкономических связей повысилась.

2. *Разделительное деепричастие*: -аад (-оод, -өөд, -ээд).  
Например:

Цас ороод хүйтэн болов.

Выпал снег и стало холодно.

### **Амьдралын аж байдал өөр болоод ч тэр юм уу?**

Может быть, это *от того, что* жизнь стала другой?

3. Причастие прошедшего времени в исходном и орудном падеже: *-снаас, -снаар*. Например:

**Монгол ардын хувьсгал ялснаар улс орны амьдрал үндсээр өөрчлөгдсөн юм.**

Благодаря тому, что (в результате того, что) победила монгольская народная революция, жизнь страны в корне изменилась.

**Бие муутай болсноос ажилдаа ирсэнгүй.**

Из-за болезни не пришел на работу.

II. Продолженное деепричастие: *-саар (-сээр, -соор, -сөөр)*:

— Действие, выраженное продолженным деепричастием, совпадает с действием, выраженным глаголом-сказуемым в конце предложения. Например:

**Энэ замаар явсаар түүнтэй ярилцав.**

*Шел по дороге и разговаривал с ним.*

— Выражает продолжительность действия, если оформляет последнее сказуемое. Например:

**АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга хоёр удаа манай оронд айлчилсныг монголчууд бид талархан дуурссар байдаг юм.**

Мы, монголы, *продолжаем с благодарностью вспоминать*, что Госсекретарь США два раза посетил с визитом нашу страну.

III. Однородные члены предложения, перечисление.

— При перечислении в монгльском языке падежом оформляется последний член предложения и перечисление заканчивается словом «зэрэг» (и так далее). Например:

**Малаас гарах үс ноос, ноолуур, сүү, мах, арьс шир, өөх тос, яс зэргийг улам ихээр ашиглаж боловсруулах, дотоод ба гадаадын хэрэгцээг хангадаг юм.**

Такие продукты животноводства, как шерсть, пух, молоко, мясо, кожа, жир, масло, кости, тщательно перерабатываются и (направляются) на удовлетворение внутренних и внешних потребностей.

**Манай ард түмэн өвөл, хавар, зун, намрын улиралд таван хошуу малаа маллаж байдаг.**

Наш народ зимой, весной, летом и осенью ухаживает за пятью видами скота.

**-тус тусын** — употребляется при перечислении, означает «в каждый из ...». Например:

**Монгол улс Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкад тус тус элссэн юм.**

Монголия вступила в Международный валютный фонд, Мировой банк, Азиатский банк развития.

(Имеется в виду — в каждый из перечисленных).

#### IV. Послелог.

Употребляются в постпозиции. Например:

**Ажил дээр ирэв.** Пришел на работу.

**Түүнээс хойш хоёр жил өнгөрлөө.**

*С тех пор* прошло два года.

При образовании атрибутивной конструкции из двух существительных, первое из которых является определением, используется послелог с аффиксом *-х (-хи)*. Например:

**Хувьсгалын өмнөх утга зохиол.**

Дореволюционная литература.

**Дайны дараахь үе.** Послевоенный период.

**Монголын засгийн газар өөрийн нутаг дээрх биологийн төрөл зүйлийг хамгаалах бодлого баримтлав.**

Правительство Монголии придерживалось политики охраны биологических видов на своей территории.

Часто в такой функции выступает дательный падеж, образуя своеобразный послелог — *дахь (дэх)*. Например:

**Монгол орон дахь гадаадынхан.**

Иностранцы в Монголии.

V. Отрицание *-гүй* употребляется с именами существительными в качестве союза «и». Например:

**өвөл зунгүй** и летом и зимой,

**өдөр шөнөгүй** днем и ночью.

## Загварууд\*

Зун цаг байсан болохоор тэдний шон дээр морь олон.	<i>болохоор</i>
БНМАУ-ыг тунхагласны улмаас тус орон шинэ замаар хөгжилөө.	<i>-сны улмаас</i>
Амьдралын аж байдал өөр болоод ч тэр юм уу?	<i>болоод ч тэр юм уу</i>
Замаар явсаар түүнтэй ярилцав. Малчин хүн өвөл зунгүй ажил ихтэй байдаг.	<i>-саар</i>
Чи хаашаа явж байна вэ?	<i>өвөл зунгүй хаашаа?</i>
Би урагшаа явж байна.	<i>урагшаа, хойшоо</i>
Монгол орон дахь гадаадынхан.	<i>дахь</i>
Герман дахь монголчууд.	
Дайны дараахь үе.	<i>дараахь</i>
Улсын хоорондохь зам.	<i>хоорондохь</i>

## ПРАКТИЧЕСКАЯ ГРАММАТИКА

**Дасгал 1.** Переведите с монгольского языка на русский устно. Обратите внимание на употребление послелогов:

### Газар ус\*

Хангай газар өндөр уултай, уулан дээр ой модтой, уулан дээгүүр цагаан цагаан үүлтэй, үүлэн дээгүүр өндөр хөх тэнгэртэй, өндөр хөх тэнгэр дор өргөн нарийн голтой, өнгө өнгийн цэцэгтэй, уулын наана талтай, уулын цаана уултай. Наад уул ногоон, цаад уул цэнхэр. Ойр, холын ой, хад, өндөр нам уул тал алаглан (пестреет) харагддаг. Үүлэн доогуур, уулан дээгүүр харцага шувуу (соколы) салхи шиг түргэн нисч байна. Ууланд гараад дээш харвал үүлтэй, үүлгүй тэнгэр харагдна. Доош харвал газар ус, уул тал, ой мод, хад чулуу, урт зам харагдна. Уулын агаар сайхан аа!

**Дасгал 2.** Вставьте вместо точек связующее звено, используйте данные обороты:

*учраас, болоод, гараад, үзснээр, улмаас*

1. Монголчууд малчин улс ... цаг агаарын байдлыг хүн бүр таамаглаж чаддаг.
2. Харьж байгаа улирал ... өдөртөө 15 градусаас илүү дулаарахгүй.
3. Урьд нь ном бичгээс ... харангуут (как только увидел) Сүхбаатарын хөшөө Сүхбаатарын талбай гэж мэдсэн.
4. Тэр гурав их сургууль дээрээс ... суудлын тэргэнд сууж баруун тийш хөдлөв.
5. Тал бүрээсээ өндөр уул, нуруугаар хүрээлэгдэж тэнгис далайгаас холдсны ... хуурай эрс тэс уур амьсгалтай.

**Дасгал 3.** Закончите предложение:

1. Монгол орны хангай говь ч нутаг элдэв .... (богата растением и животными).
2. Манай улсын нутагт Орхон, Сэлэнгэ, Хэрлэн, Онон (и много других рек есть).
3. Хэнтий нуруу бол ар өвөргүй (высокие горы, покрытые лесами).
4. (С юга и на западной окраине (зах) Хэнтэйского хребта) нам дор тал газар, өргөн хөндий байдаг.

**Дасгал 4.** Задайте пять вопросов другу, только что прибывшему из поездки по Монголии.

### **Мөнх хөх тэнгэрийн орон\*** (Тайлбарлах бичиг)

Бразилийн нийслэлд болсон Байгаль орчин хөгжлийн асуудлаархи НҮБ-ын Бага Хуралд манай улс «Монгол орны нутаг дэвсгэрийг олон улсын Онцгой хамгаалалтай дэлхийн шим мандлын тусгай бүс газар болгох» санал гаргажээ. Уг саналыг тус Бага Хурлаас дэмжин хамтран ажиллахыг сонирхогч улсууд олон улсын байгууллагуудад уриалж «Тайлбарлах бичиг» гаргасан юм.

Монгол улс бол Ази тивийн төв хэсэгт оршдог, 1,5 сая гаруй ам км нутагтай, 2,2 сая шахам хүн амтай орон юм. Монголчууд эрт дээр үеэс байгаль орчноо дээдлэж ирснээр газар, ус, ургамал, амьтны ертөнц нь онгон төрхөөрөө хадгалагдаж үлдэжээ.

Монгол улсын нутаг дэвсгэр нь их хөвч тайгын өмнөд хэсгээс эхлэн тал хээр, их говь хүртэлх Төв Азийн байгалийн өвөрмөц хэв шинж бүхий нутгийг хамардаг, эх газрын эрс тэс уур амьсгалтай, мөнх цэвдэгийн урд, элсэн говийн хойд захыг багтаасан дэлхийн шим мандлын нэн өвөрмөц тогтоцтой хэсэг юм.

Монгол улс мөнх цаст уул, мөсөн гол, унтарсан галт уул, элсэн манхан, баян бүрд, уудам тал, гүн агуй, рашаан булаг, эртний галавын ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл гэх мэт байгалийн дурсгалт зүйлээр баялаг билээ.

Мөн хүн төрөлхтний түүний дотор нүүдэлчдийн соёл иргэншлийн түүхийн дурсгалд чухал ач холбогдолтой буган чулуун хөшөө, хүн чулуу, хадны сүг зураг, эртний хиргисүүр булш, хот балгас зэрэг түүх археологийн дурсгалаар маш элбэг юм. Зөвхөн буган чулуун хөшөө 500 гаруй байна.

Тус улсын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь уулархаг өндөр газар бөгөөд нутгийн баруун хойноос зүүн урагш чиглэн тогтсон Алтайн нуруу бол манай Монгол орны хамгийн өндөр урт нуруу юм. Алтай Хангайн уулархаг нутгийн хооронд Их Нууруудын хотгор газар оршино. Увс, Хар-ус, Бөөнцагаан зэрэг манай орны томоохон нуурууд тэнд байдаг.

Монгол орны зүүн хэсэгт Хэнтий нуруу оршино. Хэнтий нуруунд Алтай Хангай нуруутай адил мөнх цаст оргил байхгүй харин ар өвөргүй ой модоор хучигдсан өндөр уулс бий.

Хэнтий уулархаг орноос зүүн тийш ба урагш өргөн тал газар бий. Энэ газрыг Монголын дорнод тал гэж нэрлэнэ. Түүнээс баруун урагш говь газар бий. Говь завсрын байдалтай говь юм.

**Дасгал 5.** Переведите текст с монгольского языка на русский письменно.

**Дасгал 6.** Переведите вопросы с русского языка на монгольский, ответьте на них по тексту:

1. Каким вопросам была посвящена Конференция ООН? 2. Какой документ приняла Конференция? 3. Где находится Монголия? 4. Сколько человек проживает на территории Монголии? 5. Почему флора и фауна Монголии сохранились в их первоначальном виде? 6. В чем специфика природы Монголии? 7. Какой в

Монголии климат? 8. Где расположены самые высокие горы в Монголии? 9. Какие три горные системы вы знаете в Монголии? 10. В чем особенность Гоби? 11. Какая разница между Алтаем и Хэнтэем? 12. Где находится Котловина Больших Озер? 13. Какие природные памятники есть в Монголии? 14. Какие археологические находки были сделаны в Монголии? 15. Какие самые известные реки Монголии вы знаете? 16. Как называется самое большое озеро? 17. Какова особенность восточных степей?

**Дасгал 7.** Найдите в тексте эквиваленты русских выражений:

биосферный заповедник  
 страны, заинтересованные в сотрудничестве  
 Меморандум  
 поклоняться природе  
 сохранились в первоизданном виде  
 территория со специфическим природным типом  
 территория Центральной Азии начинается с юга тайги до северной части Гоби  
 резкоконтинентальный климат  
 вечная мерзлота  
 вечные снега, снежник, снежная вершина  
 ледник  
 родник, источник  
 потухший вулкан  
 кочевая цивилизация

**Дасгал 8.** Соедините по смыслу две части предложения:

Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийг	багагүй анхаарал тавьдаг
Монгол Улсад байгалийн баялгаа хайрлан хамгаалахад Мал аж ахуй бол	манай орны улс ардын аж ахуйн онцгой чухал салбар юм тавиас доошгүй толгой малтай
Өнөөдөр Монгол орон	Олон улсын хамгаалалттай дэлхийн шим мандлын тусгай бүс нутаг болгох саналыг дэвшүүлээ
Монголын говь бол	хоёр сая гаруй адуутай

Айл бүр аминдаа  
Байгаль хамгаалах ажлыг

бүх нийтийн үйлс гэдэг  
Сахар арабын их цөлтэй  
адилгүй

**Дасгал 9.** Составьте небольшой рассказ по карте Монголии. Найдите географические названия, которые упомянуты в знаменитом стихотворении Д. Нацагдоржа «Миний нутаг»:

Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруунууд  
Хойт зүгийн чимэг болсон ой хөвчин уулнууд  
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд  
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон  
Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд  
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд  
Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд  
Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд  
Энэ бол миний төрсөн нутаг  
Монголын сайхан орон.

**Дасгал 10.** Поставьте глаголы в форме страдательного залога. Составьте с ними предложения на тему «Миний нутаг»:  
мартах, санах, харах, сонсох, үзэх, мэдэх.

**Дасгал 11.** Расскажите о своей родине, используйте клише:  
Миний төрсөн нутаг...

Манай нутаг сайхан. Тэнд өндөр уул уудам тал, өргөн тунгалаг гол мөрөн, ой мод, өвөрмөц онцлого бий...

## ЯРИАНУУД\*

— Та Монгол орныг сайн мэдэх үү?

— Мэднээ. Монгол орон Ази тивийн төвд оршдог. Өргөн уудам нутагтай. Нутгийн хойд тал нь уулархаг, ой модоор их. Орхон Сэлэнгэ зэрэг том том гол мөрөнтэй. Нутгийн төв хэсэг нь тал. Өмнө талаараа говьтой. Хангай говьгүй ашигт малтмалаар арвин.



- Та говьд очиж үзсэн үү?
- Үзсэн. Гурван жилийн өмнө Өмнөговь аймагт нэг очиж үзсэн. Их сонин сайхан нутаг билээ. Бас Дундговь, Дорноговь аймагт хэд хэд очсон. Зарим хүн Монголын говийг ус ч үгүй, ургамал, амьтан ч үгүй цөл гэж боддог бололтой.
- Нүдээрээ үзээгүй болоод л тэр. Хэрэв үзсэнсэн бол хаанаас тэгж бодох вэ! Би говийн тухай их соноссон. Нэг очиж үзэх юмсан гэж боддог.
- Заавал очиж үзээрэй. Их сонин шүү! Зун нь их халуун ч гэсэн, өвөл зунгүй мөстэй байдаг газар ч бий. Усаар ховор, элсэрхэг хөрстэй боловч малын сайхан бэлчээртэй. Бүтэн өдөр явсан ч захад нь хүршгүй өргөн тал ч бий. Говийнхон ажилд сайн. Говийн зоригт малчдыг харахад бахадмаар байдаг юм.
- Би саяхан нэг ном уншлаа. Говийнхныг их л магтсан байна.
- Магталгүй яахав! Магтууштай сайхан нутаг, магтмаар сайн хүмүүс.
- Хангай ч бас сайхан нутаг. Хангайнхан ч бас сайн хүмүүс шүү дээ!
- Тэгэлгүй яахав! Хангай говьгүй л сайхан. Харин хүнд төрсөн нутаг, эх орон нь л хамгийн сайхан санагддаг байх.

\* \* \*

- Та хөдөө яваад ирэв үү?
- Тэглээ. Хөдөө яваад өчигдөр орой ирлээ.
- Та ямар ажлаар яваад ирэв?
- Нутаг орны байдал үзэж аялж яваад ирлээ.
- Хаагуур, хаагуур явав?
- Архангай, Өвөрхангай, Говь-Алтай аймгаар явлаа. Их ч юм үзлээ.
- Юу юу үзэв дээ?
- Уул, тал, ой модоор явж янз бүрийн ан амьтан үзлээ. Би аргаль, янгир үзээгүй байсан юм. Сая үзлээ.
- Хулан хавтгай үзэв үү?
- Үгүй. Музейд л үзсэн.
- Хөдөө нутаг ямар байна?
- Одоо тэнгэр дулаарч, ногоо ургаж байна.
- Та Эрдэнэзууг үзэв үү?

- Үзлээ. Хархорины САА-д очлоо. Олон хүнтэй уулзаж танилцлаа. Аймгийн төвд нэг концерт үзлээ. Авьяастай залуучууд олон байна. Морин хуур, ятгаар хөгжимдөж дуу дуулж, бүжиг хийж байна. Ер нь сонирхол татах юм их байна.
- Аймгийн музейд очив уу? Аль аймгийнх нь илүү сайхан санагдав?
- Очилгүй яахав? Аль аль нь сайхан санагдлаа. Музей бүр л нутгийнхаа түүх, соёл, байгалийн баялаг, нэрт хүмүүсийнхээ амьдралыг харуулсан сайхан сайхан үзмэртэй юм.

## ХЯНАЛТЫН АЖИЛ

### *Причинно-следственная связь:*

1. Переведите с монгольского языка:
  1. Дээр үед хүүхдийн үхэл их байснаас болж хүүхдийн төрөлт бага настай холбоотой янз бүрийн ёс заншил бий болжээ.
  2. Тал бүрээсээ өндөр уул, нуруугаар хүрээлэгдэж тэнгис далайгаас холдсны улмаас хуурай эрс тэс уур амьсгалтай.
  3. Цас ороод хүйтэн болов.
  4. Манжийн эзэнт гүрэн нуран унаснаар Хятад Монгол Төвд тус тусын замаар замнах бололцоо олж авав.
  5. 1911 онд монголчууд зөвхөн өөрийн хөрш хаант Орост хандаж улс орноо хүлээн зөвшөөрч тусламж дэмжихийг хүссэн төдийгүй мөн АНУ-д хандсан билээ.
  6. Сүүлийн 2–3 жилд хэд хэдэн чухал гэрээ хэлэлцээр байгуулснаар монгол-америкийн харилцаа эрх зүйн хувьд ч батажлаа.
  7. АНУ-д одоо АНУ-Монголын бизнесийн Зөвлөл зэргийн байгууллага үүсч байгуулагдаад үйл ажиллагаагаа эхлээд байна.
  8. Энэ хөрөнгийг тусламж болгон олгосноор тухайн оронд олон улсын санхүүгийн байгууллага, бусад улстай хамтран ажиллах үүдийг нээж өгч байгаа юм.
  9. Гэхдээ танайхны хүч чармайлт, хувийн үйлдвэр, гадаадын хөрөнгө оруулагчдын ажлын үр дүнгээс их юм шалтгаалах нь мэдээж.

2. Переведите с русского языка на монгольский:
1. Так как Монголия — страна с небольшим количеством населения, ее внутренний рынок ограничен.
2. Благодаря успешному развитию сельского хозяйства поголовье скота достигло 25 миллионов.
3. Из-за того, что цены на уголь на мировом рынке падают, эта отрасль становится невыгодной.
4. Я сегодня поздно закончил работу, поэтому не зашел в магазин за хлебом.
5. Монгольский язык трудный, поэтому учиться нужно долго.
6. На улице холодно, поэтому я простудился.
7. Он сказал мне: «Приходи ровно в 16 часов», но я сидел на собрании и заставил его ждать меня 30 минут.

## Үг хэллэг

<b>байгаль</b> — природа	<b>үлдэх</b> — остаться
<b>байгаль орчин</b> — природная среда	<b>их хөвч тайга</b> — тайга, таежный лес
<b>нутаг дэвсгэр</b> — территория	<b>тал хээр</b> — степь
<b>онцгой хамгаалалтай</b> — с особой охраной	<b>өвөрмөц</b> — специфический
<b>шим мандал</b> — биосфера	<b>хэв шинж</b> — тип, свойство
<b>Олон улсын онцгой хамгаалалтай дэлхийн шим мандлын тусгай бүс газар</b> — Биосферный заповедник	<b>хэв шинж бүхий</b> — обладающий типом...
<b>бүс газар</b> — зона, регион	<b>хамрах (хамаарах)</b> — охватывать, иметь отношение
<b>бүс нутаг</b> — регион	<b>эх газрын</b> — континентальный
<b>санал гаргах</b> — выдвинуть предложение, инициативу	<b>эрс тэс уур амьсгалтай</b> — резко-континентальный климат
<b>дэмжих</b> — поддерживать	<b>уур амьсгал</b> — климат
<b>шахам</b> — почти	<b>мөнх цэвдэг</b> — вечная мерзлота
<b>дээдлэх</b> — почитать, поклоняться	<b>элсэн говь</b> — песчаная пустыня
<b>ургамал</b> — растительность;	<b>говь</b> — в монгольском языке «говь» не означает географическое название, это — пустыня
<b>ургах</b> — расти	
<b>онгон төрх</b> — первозданный вид	<b>багтаах</b> — включать в себя
<b>хадгалах</b> — хранить	<b>тогтоц</b> — строение, система, структура
<b>хадгалагдах</b> — сохраниться	

**мөнх цаст уул** — вечные снега;  
**мөс** — лед  
**галт уул** — вулкан  
**унтарсан** — потухший  
**баян бүрд** — оазис  
**агуй** — пещера  
**булаг** — ключ, источник  
**булш** — могильник  
**булах** — зарывать, закапывать  
**эртний галав** — древний период  
**амьтны чулуужсан үлдэгдэл** —  
окаменевшие останки жи-  
вотных  
**дурсгалт зүйл** — памятник  
**хүн төрөлхтөн** — человечество  
**нүүдэлчдийн соёл иргэншил** —  
кочевая цивилизация  
**ач холбогдолтой** — иметь значе-  
ние  
**буган чулуун хөшөө** — «оленные  
камни»

**хүн чулуу** — каменная баба  
**хадны сүг зураг** — рисунки и  
надписи на скалах  
**хиргисүүр булш** — киргизские  
могильники  
**хот балгас** — развалины древних  
поселений  
**зөвхөн** — только  
**уулархаг** — гористый  
**элсэрхэг** — песчаный  
**усархаг** — водный  
**чиглэн тогтсон** — протянулся  
**Их Нууруудын хотгор** — Котлови-  
на Больших Озер  
**оргил** — вершина  
**ар өвөргүй** — и с севера, и с юга  
**хучих** — покрывать  
**хучигдсан** — покрыты  
**завсрын байдалтай говь** — полу-  
пустыня

## ШАМАНИЗМ БӨӨГИЙН ҮЗЭЛ

К концу 1 тыс. до н.э. шаманизм в Центральной Азии и Южной Сибири в структурном плане получил свой законченный вид. К нему восходят шаманские верования всех монгольских народов позднейших времен, а также тюркоязычных народов Сибири. Его самый ранний слой соответствует тотемическим верованиям. Пережитками тотемического сознания являются дошедшие до нас представления о тотемных предках: волке *чоно*, лебедю *хун шувуу*, орле *бургэд*, медведе *баавгай*, и т. д. Шаманизм одухотворяет весь мир, каждое явление природы: каждая местность имеет своего духа (*лус савдаг*). Возникли обряды жертвоприношения *тайлган* и *тахил*. Например, *овоо тахих* жертвоприношение в честь курганов обо (насыпь из камней, земли, веток на перекрестке дорог, у воды или на перевале; *хайрхан уул тахих* обряд жер-

твоприношения в честь священной горы и т. д. Верховным божеством в шаманизме является Синее небо — *Хөх тэнгэр*. В эпоху патриархально-родового строя шаманизм выступает как одна из форм общественного сознания. Постепенно по мере разложения родового строя и появления ранних государственных объединений (хуннов, сяньби, жужаней) усложняется обрядовая система шаманизма, возникает институт шаманского избранничества, особая школа подготовки и посвящения шаманов и т. п. Шаман жрец играл важную роль в политике ранне- средневековых государств.

## ИЗ ИСТОРИИ МОНГОЛИИ

### ГРАММАТИКА

1. Притяжение «-х» употребляется с дательным и родительным падежами. Например:

Онон мөрний хөвөөн дэх.	На берегу реки Онон.
Энэ кино Монголынх.	Этот фильм монгольский.

2. *Тухайлбал* — «а именно», «в частности» вводное слово.

3. *Төдий* — союз «настолько», «только», «всего-навсего».

4. *Хэдий тийм боловч* — несмотря на это.

5. *нь* — употребляется как субстантиватор после причастий, оформляет группу подлежащего, выраженного глаголом. Например:

Урлаг хөгжиж байсан нь.  
Развитие искусства,

6. *Аффикс -тан* генетически восходит к аффиксу совместного падежа *-тай*: *т* — совместный падеж; *а* — разделительный гласный; *н* — скрытый *н*.

Монгол хэлтэн аймаг — монголоязычные племена.

7. *хийгээд, бөгөөд, болон* — соединительные союзы «и».

8. **-хуйц, -ууштай** — аффиксы прилагательного, переводятся êâê «çà è, èâà ù èé...». Например:

магтууштай	похвальный
мэдэгдэхүйц	заметный.

9. **Глаголы в страдательном залоге** требуют дательного падежа, например:

захиргаанд нухлагдсан — страдали от господства.

10. **Глаголы в побудительном залоге** требуют винительного падежа или притяжения. Например:

Тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан  
— восстановили независимость.

11. **XVII зууны эцэс гэхэд** — к концу XVII века.

## **ПРАКТИЧЕСКАЯ ГРАММАТИКА**

Дасгал 1. Разберите слова по составу, восстановите первоначальную основу глагола или существительного:

Нүүдэлчид, байдалтай, аймгуудын, олдвороос, мэдэгдэх, дурсгалын, нэгтгэж, үзэгдэл, дэвшилттэй, бариулах, хороололтой, хуралдайгаар, мэдэгдэхүйц.

Дасгал 2. Переведите на русский язык:

нэгэн үед, хожмын үед, ойрын үед, дээр үед, манай үед, өнөө үед, орчин үед, залуу үед, залуу үе, өсвөр үе, түрэгийн үе, тухайн үе, тэр үе, манай эриний завсар үед, сүүлчийн үе.

Дасгал 3. Переведите на русский язык, дополните ряд слов:

Монгол хэлтэн, амьтан, ажилтан, номтон, эрхтэн, угсаатан, хүчтэн, овогтон...

Дасгал 4. Выберите из текста парные слова и продолжите ряд:  
газар нутаг, эрх ашиг, улс гүрэн...

**Дасгал 5.** Найдите в тексте причастие в винительном падеже в функции дополнения с глаголами. Например: *нэгтгэн захирахыг эрмэлзэх* — стремиться захватить.

**Дасгал 6.** Переведите с русского языка на монгольский:

1. Я не знаю, где живет Дорж. Знает только Дулма. 2. Я не знаю, где продается молоко. Спросите у продавца. 3. Я не знаю, сколько книг в этой библиотеке. 4. От кого ты узнал, что он приехал (он приезжает) из Москвы? 5. В прошлом году Туяа не могла говорить по-русски. А сейчас хорошо говорит (стала говорить). 6. В детстве я не умел кататься на коньках. Сейчас хорошо катаюсь. 7. Как только увидел Батбаяра, сразу его узнал. 8. Они пришли сюда, чтобы помочь нам. 9. Учитель Шарху преподает или маньчжурский или старописьменный язык. 10. Подождите здесь, пока я не приду. 11. Когда я пришел, уроки уже начались. 12. Я не знаю, что мне делать. 13. Они не только обсуждали эту проблему, но горячо спорили.

### **Монгол орны түүхээс\***

Манай эриний завсар үед Төв Азийн ихэнх нутгийг эзэлж байсан Хүннү гүрэн бол монголчуудын өвөг дээдсийн анхны төр улс байсан юм. Хүннү гүрэн Хятадын Хан улстай өрсөлдөн тэмцэлдэж нэгэн үе сүрхий хүчирхэг байв. Манай эриний 198 онд Хүннү Хятадын хооронд тусгай гэрээ байгуулагдаж Цагаан хэрмээс хойши газар нутгийг хүннүчүүд эзэмшиж байх болжээ. Хүннү гүрэн Дорно Өрнийн олон улстай өргөн харилцаатай байсан бөгөөд нүүдэлчдийн соёл иргэншлийг бусад улс гүрэнд түгээж байжээ. Хүннүгийн гүрний дараа тогтсон томоохон улс бол түрэгийн хаант улс юм (манай эриний VI—XIII зуун). Хатан Туул, Онон, Хэрлэнгийн монголчууд биеэ даасан байдалтай байсан бөгөөд Түрэгийн хаанд алба татвар өгөх төдий байжээ. Энэ үед Түрэг Монгол аймгуудын хэл хоорондоо ихээхэн холилдож хожмын үед чухам ямар үг нь монгол, түрэг болохыг ялгаварлахад бэрх болжээ.

Түрэгийн үед нүүдэлчдийн соёл, тухайлбал бичиг үсэг, уран барилга, чимэглэх урлаг хөгжиж байсан нь археологийн олдвороос мэдэгдэж байна. Орхоны бичээс гэж алдаршсан



чулуун дээр сийлсэн түрэг бичиг бол дэлхий дахины соёлын ховор дурсгалын нэг юм.

Тус улсын нутагт оршин тогтнож байсан оөр нэг томоохон улс нь Монголын Кидан гүрэн (манай эриний IX зуун) байв. Кидан нар монгол хэлтэн аймаг байсан бөгөөд дараах үеийн монголчуудын түүхэнд мэдэгдэхүйц ул мөрөө үлдээсэн билээ. Кидан гүрний дараагаар монгол аймгууд түүхийн тавцанд гарч иржээ.

1204—1205 оны үед Тэмүүжин монгол аймгуудыг дэс дараалан нэгтгэн захирах болжээ. Монгол аймгуудыг нэгтгэж дуусмагц 1226 онд Онон мөрний хөвөөн дэх Дэлүүн Болдогт хуралдсан монголын феодал ноёдын их хуралдайгаар Тэмүүжинг бүх Монгол улсын хаан болгон өргөмжлөв.

XIII зууны эхэн үед Монголын нэгдсэн улс ийнхүү байгуулагдсан нь монгол аймгууд нэгэн ард түмэн болон нягтрах, монгол хэл бүрэлдэн тогтох зэрэг цаашдын түүхэн дэвшил хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хэдийгээр энэ нь тухайн үед дэвшилттэй үзэгдэл байсан боловч феодал язгууртны эрх ашгийг хамгаалагч хаад ноёд ард түмнийг хатуу ширүүнээр дарлан мөлжиж монголын феодалууд олз ашиг олохын төлөөнөө бусдын нутаг, эд баялгийг дээрэмдэж эзлэн түрэмгийлэх аян дайны замд орсон юм.

Эртний монгол аймгуудын нэгэн нийслэл хот байсан Хар Хорумыг 1235 онд Өгөөдэй хааны зарлигаар өргөтгөн орд харш нэмэн бариулж эргэн тойрон бэхлэлт хэрэмтэй, олон угсаатны хороололтой болгожээ.

Монголын эзэнт гүрэн нь өөртөө нийтлэг эдийн засгийн бааз суурьгүй, үнэн чанартаа Монголын феодалуудын хүнд дарлал хийгээд тэдний цэрэгжсэн захиргаанд нухлагдан нэрвэгдсэн угсааны олон аймаг овогтны эрээвэр хураавар бүрэлдэхүүнтэй хэврэг гүрэн байсан тул дорнын улс түмний эрх чөлөөний хөдөлгөөний хүчтэй цохилтод нуран унасан билээ.

Монгол орны нийгэм-эдийн засгийн харилцааны хөгжлийн түвшин нь харилцан адилгүй эрс зөрчилтэй болсон нөхцөлд монголын феодалын бутрал улам гүнзгийрсэн байна. Энэ нь эцэс сүүлдээ харийн түрэмгийлэгч манж нарт эзлэгдэх үндсэн шалтгааны нэг болжээ. Бие биетэйгээ өрсөлдсөн олон жижиг

ханлиг бие даасан феодалын эзэмшил болон хувирч нэгэн хааны төвлөрсөн засагт захирагдахгүй болж монголын төрийг хэврэгшүүлжээ. Түүний дээр Хятадын Мин улс баруун зүүн монголын алийг нь ч хүчтэй болгохгүй, суларсны нь дэмжиж тэдний хүчийг «тэнцүүлэх» замаар хутган үймүүлж монголын феодалын бутралыг улам гааруулан, завсраас нь завших хорт бодлого явуулж байжээ.

Хэдий тийм боловч феодалын бутралыг хязгаарлан бүх монголын хааны эрх мэдлийг сэргээх гэсэн оролдлого гарч, зарим талаар түр амжилт олж байсан Даян хаан Батмөнх Мандухай цэцэн хатан нарыг энд дурдах хэрэгтэй.

Монголын хаанд өргөмжлөгдсөн Лигдэн (1592—1634) нийт монголчуудыг нэгтгэн захирахыг эрмэлзэж тэр үед хүчирхэгжиж байсан манжийн түрэмгийлэгчдээс тусгаар тогтнолоо хамгаалах эрчимтэй тэмцэл хийх зорилт тавьсан боловч амжилт олсонгүй.

XVII зууны эцэс гэхэд Монгол орон Манж гүрэнд эзлэгдэж 200 гаруй жилийн турш тэмцэлдсээр 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан билээ.

## Дасгалууд

**Дасгал 7.** Прочтите текст и переведите его.

**Дасгал 8.\*** Переведите на слух следующие предложения и словосочетания:

Хүннү Хятадын хооронд тусгай гэрээ байгуулагдав.

Дорно Өрнийн олон улстай өргөн харилцаатай байсан.

Нүүдэлчдийн соёл иргэншил, бие даасан байдал, алба татвар, алба хаах, бичиг үсэг, уран барилга, чимэглэх урлаг, археологийн олдвор, чулуун дээр сийлсэн түрэг бичиг, дэлхий дахины соёлын дурсгал.

**Дасгал 9.** Переведите с русского языка на монгольский:

Независимость, кочевая цивилизация, памятник культуры, монголоязычные племена, защищать интересы, аристократия, прогресс, играть важную роль, грабить, объединять, историческая арена, управлять, объединенное государство, централизованная

власть, общность экономического базиса, тяжелый гнет, состав, в конце концов, уровень социально-экономического развития, разрозненные мелкие государства, Монголия была захвачена маньчжурами, предки, государство.

**Дасгал 10.\*** Ответьте на вопросы:

1. Хүннү гүрэн хэзээ хаана оршин тогтносон бэ? 2. Цагаан хэрмээс хойшхи нутгийг ямар аймгууд эзэмшиж байв? 3. Хүннүгийн дараа ямар улс тогтсон бэ? 4. Түрэгийн хаан улс ямар онцлоготой байв? 5. Түрэгийн улс монголчуудтай ямар харилцаатай байсан бэ? 6. Төв Азийн нутаг оршин тогтнож байсан томоохон улсыг нэрлэнэ үү? 7. Монгол аймгууд хэзээ түүхийн тавцанд гарч ирсэн бэ? 8. Монгол аймгуудыг нэгтгэсэн түүхийг ярина уу? 9. XIII зууны эхэн үед Монгол нэгдсэн улс байгуулагдсан нь ямар ач холбогдолтой байв? 10. Монгол аймгууд нэгэн ард түмэн болон нягтарсаны үр дүнд юу болсон бэ? 11. Эртний монгол аймгуудын нийслэл юу байв? 12. Монгол-Хятадын харилцаа дунд зууны үед ямар байв? 13. Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэж байсан хаадыг мэдэх үү? 14. Монгол орон хэзээ Манж гүрэнд эзлэгдсэн бэ? 15. Хэдэн онд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан бэ?

**Дасгал 11.** Придумайте предложения со словами:

төр, улс, гүрэн, орон, улс төрийн, улс гүрэн, улс түмэн.

**Дасгал 12.\*** Ответьте на вопросы:

1. Хувьсгалаас өмнө Монгол орон ямар байв? 2. Ардын хувьсгал ялахаас өмнө Монгол оронд ажилчин анги байсан уу? 3. Манай сургуулийн номын санд Монголын тухай уншмаар ном байна уу? 4. Д. Нацагдоржийн «Миний нутаг» гэдэг шүлэг хэдэн онд хэвлэгдсэн бэ? 5. Таны өрөөний цонхоор юу харагдаж байна вэ?

**Дасгал 13.** Допишите следующие предложения:

Би ... үзэх дуртай.

Хөдөөгийн амьдрал бол ... байдаг.

Манай нутагт өвөл ... байдаг.

Аугаа их эх орны дайны үед миний аав ... тэмцэж байсан.

**Дасгал 14.** Переведите на слух:

### **Аянга эмчилсэн нь\***

Америкийн иргэн Жекоб Стоун хоёр жилийн өмнө маш хортой могойд хатгуулж бараг харахгүй, сонсохгүй болсноос гадна хөл гар нь мэдээ алджээ. Эмч нар янз бүрийн арга хэрэглэсэн боловч тус болсонгүй. Өнгөрсөн онд Стоун байшингийнхаа гадаа сууж байтал бөмбөгөн аянга түүний ойролцоохь модыг ниргэжээ. Түүнээс хойш 30 минут орчмын дараа Стоуны хараа нь сайжирч, сонсгол нь хэвийн болсон гэнэ.

**Дасгал 15.** Переведите письменно:

География обсуждения проблем, относящихся к установлению мира и безопасности в азиатско-тихоокеанском регионе, расширяется изо дня в день. Это вновь подтверждает неделимость и взаимосвязанность нашей хрупкой Планеты. И Запад, и Восток в одинаковой степени заинтересованы в налаживании взаимовыгодного сотрудничества со странами этого региона в области экономики и политики. Монгольская столица в этом году стала местом проведения нескольких конференций и совещаний. В них участвовали ученые и дипломаты, парламентарии и политики, профсоюзные и молодежные деятели, представлявшие фактически все континенты. В Улан-Баторе недавно успешно завершила работу международная научная конференция на тему «Новое мышление: актуальные проблемы АТР», организованная Институтом востоковедения Академии наук Монголии.

**Дасгал 16.** Вместо точек вставьте подходящее слово, данное в скобках:

1. ... чөлөөний нар гарав. Тэртээ модтой ... харагдав.  
(уул, үүл)
2. Энэ гудамж ... ихтэй байна. Манайх эндээс ... суудаг.  
(хол, хөл)
3. Монгол орос толь ... болсон. Манай орон сансар эзэмшихэд амжилт ... .  
(олдох, олох)
4. Би нэг ах хоёр ... . Миний нэг найз ... дуулах юм.  
(дүү, дуу)

5. Тэр Улаанбаатар очоод ... . Би найзыгаа нисэх онгоцны буудлаас ... .  
(гарах, гаргах)
6. Олон улсын харилцаа хөгжих, энх тайвны тэмцэлд улам олон хүн оролцсоны ... . Ширээнд тавьсан олон номын ... минийх бий.  
(дүнд, дунд)
7. Тэр надаас харандаа ... . Тэр надаас түргэн ... .  
(Гуйх, гүйх)
8. Энэ ... таних уу? Олон ... нуурандаа байна уу?  
(хун, хүн)

### ЯРИАНУУД\*

- Та Д.Нацагдоржийн «Соёлыг гайхав» гэдэг өгүүллийг уншив уу?
  - Уншлаа. Их сонин өгүүллэг байна.
  - Тийм ээ. Их сонин шүү. Лувсан өвгөний байдлыг яг л зурсан юм шиг бичсэн байдаг. Бас бодол санаа нь яаж өөрчлөгдсөнийг сайхан гаргасан байдаг.
  - Хувьсгалаас өмнө Монголд нисэх онгоц байгаагүй юу?
  - Байгаагүй ээ. Машин, автобус, галт тэрэг, аль нь ч байсангүй. Морь, тэмээгээр явж, үхэр тэрэг, морин тэргээр ачаа зөөдөг байсан юм.
  - Одоо монголын ард түмний аж амьдрал тэр үеийнхээс гайхмаар их өөрчлөгджээ.
  - Тиймээ. Манай орон, үндэсний аж үйлдвэртэй болж, хөдөө аж ахуй ч их хөгжлөө. Улс хөгжих тусам ард түмний аж амьдрал улам сайхан болж байна.
- \* \* \*
- Та Африкт очиж үзсэн үү?
  - Үгүй. Та очиж үзсэн үү?
  - Үзсэн. Би одоогоос 3 жилийн өмнө Алжир улсад нэг очсон.
  - Та усан онгоцоор явсан уу? Нисэх онгоцоор уу?
  - Нисэх онгоцоор. Галт тэргээр Москвад очоод тэндээс нисэх онгоцоор явсан юм.

- Москвад удсан уу?
- Хоёр хоносон. Би Москвад очингуутаа л цаашаа явъя гэтэл Алжир луу тэр өдөр явах онгоцны билет дуусчихаж. Тэгээд Москвад хоёр хонох боллоо.
- Та тэнд 2 хонохдоо юу хийв дээ? Их юм үзэв үү?
- Их юм үзэж чадаагүй. Эхний өдөр гадуур жаахан явлаа. Харин онгоц нисэх өдөр «Төөрөөд, онгоцноос хожимдчих байх» гэж айгаад гадагшаа гараагүй.
- Алжирт удаж хүрэв үү?
- Үгүй, удалгүй хүрсэн. Москвагаас оройхон гараад замдаа буулгүй нисэж үүрээр Алжир хотын нисэх онгоцны буудал дээр буулаа.
- Таныг хүн угтаж авав уу?
- Авсан. Алжирын сэтгүүлэгчдийн байгууллагаас намайг угтаж авахаар нэг хүн ирсэн байлаа. Харин би тэр хүнийг танилгүй, таксинд суугаад хот руу явчих шахсан шүү.
- Тэгээд яаж тэр хүнтэйгээ уулзав?
- Таксинд суугаад явахаар завдаж байтал тэр нутгийн бололтой нэг хүн ирж «Та Монголоос ирсэн сэтгүүлч мөн үү» гэж асуулаа. Тэр хүн намайг угтаж авахаар ирсэн хүн байж л дээ.

\* \* \*

- Чи ямар ном авч яваа юм бэ?
- Монголын эдийн засгийн газар зүйн сурах бичиг.
- Хаанаас аваав? Номын дэлгүүрт гарч байна уу?
- Номын 1-р дэлгүүрээс авлаа. Тэнд хориодхон гараад дуусчихлаа.
- Дахиад гарах бол уу? Надад бас хэрэгтэй байна.
- Маргааш номын 3-р дэлгүүрт гарна гэнэ.
- Номын 3-р дэлгүүр чинь хаана байдаг юм бэ? Би хаа байдгий нь мэдэхгүй юм.
- «Туул» рестораны ард жижигхэн дан цагаан байшинд байдаг юм.
- Өглөө хэдэн цагт онгойх бол? Чи мэдэх үү?
- Өглөө 9 цагт онгойх хуваарьтай. Өдөр 1 цагаас 2 цаг хүртэл завсарлаад орой 5 цагт хаадаг юм.

Дасгал 17. Переведите с монгольского языка на русский:

### **Хэмнэсэн нь\***

Габровын хос залуу Римд очиж зочид буудалд ороод хотыг үзэхэд хичнээн хугацаа зарцуулахыг асуухад дөрөв хоногоос багагүй хугацаа хэрэгтэйг тайлбарлажээ. Хоёр өдрийн дараа Габров хотын хос залуу явцгаахаар зочид буудалтай тооцоо хийх гэсэнд хүмүүс их гайхаж,

— Та нар хоттой яаж ийм түргэн танилцаа вэ? гэж асуухад,

— Маш амархан. Миний эхнэр хотын нэг хэсгийг, би нөгөө хэсгийг нь үзсэн. Тэгээд Габровтоо буцаж очмогц бие биендээ өөрсдийнхөө үзсэнийг ярина гэж залуу хариулжээ.

Дасгал 18. Переведите с монгольского языка на русский:

### **Явах нь багасчээ\***

Явган явах нь эрүүл мэндэд ашигтайг хүн бүр сайн мэднэ. Гэтэл энэ зууны эхэнд хүн амьдралынхаа туршид дунджаар 75 мянган км явган явдаг байсан бол орчин үед тээврийн хэрэгсэл ихэссэнээс энэ тоо гурав илүү дахин багасчээ. 2035 он гэхэд хүн явганаар бараг явахгүй болно гэж мэргэжилтнүүд тооцоолсон байна.

Дасгал 19. Перескажите по-русски маленькие истории из двух предыдущих упражнений.

## **ХЯНАЛТЫН АЖИЛ**

I. Переведите с монгольского языка на русский:

### **Шинэ жаран туулай жилээр эхэллээ\***

Жарны тооллыг 1027 оны улаагчин туулай жилээс манайх эхэлсэн бөгөөд өнөөдөр хаврын тэргүүн бага цагаан барс сарын шарагчин туулай өдөр бол арван долдугаар жарны улаагчин туулай жилийн ууган өдөр юм.

Монгол улс дэлхийн зуу гаруй оронтой дипломат харилцаатай болж, соёл, эдийн засгийн харилцаа бүхий орны тоо хэдэн аравт

хүрч, олон улсын нэр хүнд өсөн нэмэгдсээр ирэв. Өнөөдөр манай орон нэг хүн амд ногдох мах, ноос, улаан буудай, цахилгаан эрчим хүч, зарим төрлийн эрдэс түүхий эд, өнгөт металлын үйлдэхүүн, түмэн хүнд ногдох оюутан сурагч, эмч, бусад мэргэжилтний тоогоор дэлхийн олон орноос тэргүүлж явна. Спортын дэвжээн дээрээс ч дэлхийн цөөнгүй аварга төрөв.

Монголын газрын зураг дээр шинэ шинэ хот суурин сүндэрлэн бослоо.

Хууччуул туулайг билэгдэл сайтай жилийн тоонд оруулдаг. Шинэ жарны эхэн — улаагчин туулай жил хүмүүст ажлын шинэ амжилт сайн сайхны итгэл төрүүлж, аюулт дайны сүүдрийг зайлуулж, бат бэх энх тайвны он болох нь дамжиггүй.

2047 онд арван долдугаар жаран дуусах хүртэл манай дэлхий цөмийн зэвсэггүй, дайны аюулгүй, итгэлцэл, хамтын ажиллагаа, сайн хөршийн ёс түгээмэл дэлгэрсэн энхийн гариг болох нь эргэлзээгүй билээ.

## II. Переведите с русского языка на монгольский:

1. Монголия выдвинула предложения о заключении Конвенции о взаимном ненападении и неприменении силы в отношениях между государствами азиатско-тихоокеанского региона.
2. По мере развития производительных сил сокращается рабочее время, улучшается обслуживание.
3. Провозглашение МНР стало событием всемирно-исторического значения.
4. Благодаря провозглашению МНР юридически (хуулиар) было закреплено то, что подлинным хозяином независимой, свободной страны является только трудовой народ Монголии.
5. Проведение митинга может вызвать напряженность не только в столице, но и во всей стране.
6. Принятие закона негативно отразится на работе предприятий.
7. Шахтеры беспокоят Кремль. Если в начале марта бастовали лишь несколько шахт, то теперь бастует четвертая часть из 600 шахт страны.
8. Из-за того, что разные страны стоят на разных ступенях развития, они по-разному трактуют одни и те же проблемы.



9. Благодаря приходу к власти Горбачева международное положение, определявшееся «холодной войной», коренным образом изменилось.
10. В результате повышения цен на основные товары жизнь простых людей в стране ухудшилась.

## Үг хэллэг

аймаг овогтон — племена  
 эрээвэр хураавар бүрэлдэхүүн  
 — пестрый состав  
 бутрал — раздробленность  
 эрс зөрчилтэй — резкое противоречие  
 харийн түрэмгийлэгч — иноземные захватчики, интервенты  
 манж — маньчжуры  
 шалтгаан — причина  
 эзэмшил — вотчина  
 болон хувирах — превратиться  
 хэврэгшүүлэх — разрушить, раздробить  
 сулрах — ослабнуть  
 хутган үймүүлэх — вносить рознь, ссорить  
 гааруулах — усугубить  
 эрх мэдэл — полномочия  
 оролдлого — попытка  
 завсраас нь завших — опасная политика вмешательства  
 хорт бодлого — опасная политика  
 сэргээх — возрождать  
 тэнцүүлэх — уравнивать  
 манай эриний завсар үед — на рубеже нашей эры  
 Гүрэн — держава, государство  
 өрсөлдөн тэмцэх — конкурировать

сүрхий хүчирхэг — могущественный  
 Цагаан хэрэм — Великая Китайская стена  
 эзэмших — владеть  
 соёл иргэншил — цивилизация  
 түгээх — распространять  
 алба татвар — налоги  
 холилдох — смешиваться  
 хожмын үед — впоследствии  
 ялгаварлах — различать  
 уран барилга — архитектура  
 чимэглэх урлаг — прикладное искусство  
 олдвор — находки  
 бичээс — надписи  
 алдаршсан — прославленный  
 сийлсэн — резьба  
 дурсгал — памятник  
 оршин тогтнож байсан — существовало (государство)  
 ул мөр — след  
 захирах — управлять  
 хөвөөн — берег  
 өргөмжлөх — возвести, провозгласить (ханом)  
 бүрэлдэн тогтох — сформироваться  
 үзэгдэл — явление  
 хэдийгээр... боловч — хотя и...  
 феодал язгууртан — класс феодалов, аристократия

тухайн үе — в то время  
хатуу ширүүнээр — жестоко  
дарлан мөлжих — эксплуатиро-  
вать  
олз ашиг — выгода  
дээрэмдэх — грабить  
эзлэн түрэмгийлэх — завоевы-  
вать  
эзлэн түрэмгийлэх аян дайн  
— завоевательные походы


угсаатан — народность  
нухлагдан нэрвэгдсэн — стра-  
дающий  
нэгэн үе — один период  
эрээвэр хураавар — пестрый,  
разнообразный  
нэгэн ард түмэн болон нягт-  
рах — объединились,  
сплотились в один народ  
турш — в течение (последлог)

## КОСМОГЕНЕЗ МОНГОЛОВ

1. АРГА БИЛИГ — дуалистическое мировоззрение древних монголов, соответствует кит. иньян. С древности монголы почита-ли небо (*арга*) как средоточие мужского, сильного начала, и назы-вали небо «отцом», а землю (билиг) — «матерью». Единство не-бесных и земных сил издревле использовалось и в медицине. Так, например, «холодные» недуги лечили горячими средствами (при-жигания), а «горячие» — холодными (холодные ванны).

### 2. ПЯТЬ ЭЛЕМЕНТОВ

Изучая влияние природных факторов на человека, жители стран Дальнего Востока нашли, что все живые и неживые существа на земле состоят из пяти основных элементов или стихий — *мод* дерева, *гал* огня, *шороо* зем-ли, *төмөр* железа (металла) и ус воды. О происхождении этих пяти элементов рассказывают следую-щую легенду:



Давным-давно, в прежние време-на жил-был меткий стрелок-охотник. Однажды охотился он на берегу озе-ра да и подстрелил диковинного зве-ря. То была черепаха. Она упала, подстреленная, и перевернулась, ле-жит кверху брюхом. Подошел к ней охотник. Видит — в четырех лапах

комки глины. Под передними лапами торчит обломок деревянной стрелы с железным наконечником, живот раздулся, как воздушный шар, изо рта жар пышет, из другого отверстия вода выливается. Смотрел, смотрел охотник и решил, что земля, железо, дерево, вода и огонь (горячий воздух) — это и есть те пять первоэлементов, из которых состоит Вселенная. На панцире черепахи узоры — ровно 12 рисунков разных животных. Вот охотник и распределил пять элементов между этими животными. Так получился 60-летний календарный цикл. Для жителей Китая и Монголии панцирь черепахи служил как бы естественной гадальной доской: даже книга «И Цзин», как известно, восходит к гаданию на панцире черепахи.

## НАРОДНОЕ ХОЗЯЙСТВО

## ГРАММАТИКА

1. Придаточное дополнительное предложение в монгольском языке:

*Подлежащее придаточного дополнительного предложения* (местоимение или существительное) оформлено родительным падежом, сказуемое — причастием в винительном падеже. Например:

**Чи миний ирснийг ахад хэл.**

Скажи брату, что я пришел.

**Миний аав ээжийн хөдөө суудгийг та мэдэх үү?**

— Вы знаете, что мои родители живут в худоне?

**Маргааш хурал болохыг чи мэдэх үү?**

— Ты знаешь, что завтра собрание?

2. *Придаточное предложение* часто оформляется союзом *гээж* или *гэдгийг*. Например:

**Чамайг ирнэ гэж би мэдсэн. Я знал, что ты придешь. Төлөөлөгчид сэтгэл ханамжтай гэдгийг (байгаагаа) илэрхийлэв.**

Делегаты выразили удовлетворение.

3. *Болох* в сочетании со смысловым глаголом в форме инфинитива: *-х болсон* или *-хаар болсон* означает преднамеренность действия в будущем. Переводится на русский язык простым будущим временем. Например:

**Би явах болсон. Я поеду.**

#### 4. *Отрицательное деепричастие -лгүй:*

байлгүй    как не быть,  
уншилгүй    не дочитав...

#### 5. *Союз «не только, но и...»:*

Зөвхөн... төдийгүй...  
-аар барахгүй  
— байтугай.

#### 6. *Тэр ч байтугай...*    Более того, вводное слово.

## ***ПРАКТИЧЕСКАЯ ГРАММАТИКА***

**Дасгал 1.**    Переведите словосочетания, используя клише:

...талаар хамтран ажиллах  
-ын хамтын ажиллагаа  
...салбар дахь хамтын ажиллагаа  
...салбарт хамтран ажиллах

1. Двустороннее сотрудничество. Мы будем развивать двустороннее сотрудничество. Мы будем развивать сотрудничество между двумя нашими странами. 2. Культурное сотрудничество, экономическое сотрудничество. 3. Сотрудничество в области науки и культуры. 4. Межправительственное соглашение о сотрудничестве в области энергетики. 5. Подписан протокол о сотрудничестве в области внешней торговли. 6. Подписан протокол о поставках товаров и платежах. 7. Стороны обменялись мнениями о сотрудничестве в области космических исследований.

**Дасгал 2.**    Переведите с монгольского языка на русский, обратите внимание на значение усилительной частицы ч:

1. Ууланд ч усанд ч хөрсөнд ч хөрсөн дор ч бас баялаг бий.  
2. Хүн чулуу ч (хүртэл) бодолд ормоор хэрвоо юм аа. 3. Залуу зандан явахдаа ч ирээдүйнхээ тухай бодоход надад сонин байна.  
4. Одоо өнгөрснийг бодоход ч надад сонин байна. 5. Өнөөдөр тэнгэр сайхан ч гэсэн өчигдөр цас орсон байлаа.

**Дасгал 3.\*** Переведите с монгольского языка причастные обороты:

1. Төслийг хэрэгжүүлэх явц. 2. Төслийг хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээл. 3. Дэлхийн эдийн засагт чухал ач холбогдолтой үйл хэрэгт оролцсон улс. 4. Хөгжиж байгаа орон. 5. Улаанбаатар хотноо байгуулагдсан Монгол судлалын холбоо. 6. Олон Улсын Валютын сантай байгуулсан хэлэлцээр. 7. Хамтран боловсруулсан хөтөлбөр. 8. ЗХУ-ын бүх цэргийг Монголоос гаргах сүүлчийн хугацаа. 9. Хоёр улсын хооронд асуудлыг зохицуулах ерөнхий зарчим.

**Дасгал 4.** Переведите на монгольский язык:

1. По мере развития промышленности в Монголии появился рабочий класс. 2. В основном Монголия экспортирует продукцию легкой, пищевой и горнодобывающей промышленности. 3. Несмотря на трудности военного времени, в 1941—1945 гг. экономика страны неуклонно развивалась. 4. Важное значение для дальнейшего укрепления материально-технической базы народного хозяйства имело становление молодой промышленности. 5. Д. Нацагдорж был не только великим поэтом, но и общественным деятелем. 6. Не говоря ни слова, он вышел из аудитории. 7. Не дочитав книгу, я вернул ее в библиотеку. 8. Вы идите туда, а я пойду дальше. 9. Отправленный по железной дороге в Улан-Батор груз еще, наверное, не дошел. 10. После установления дипломатических отношений между Россией и Монголией прошло более 70 лет.

**Дасгал 5.** Переведите с монгольского языка на русский, учитывая разное значение глагола *болох*:

1. Мне бы хотелось приобрести машину. 2. В прошлом году мой брат женился. 3. В этой аудитории сейчас собрание. 4. Можно войти? Здесь нельзя курить. 5. Мой сын скоро станет врачом. 6. Сколько времени? 7. Он стал учителем недавно. 8. Еще не пора начинать урок. 9. Я буду изучать иностранный язык. 10. Изменилось расписание самолетов, и я поеду завтра. 11. Дождь все усиливается. 12. Из-за того, что у меня нет времени, мы не могли встретиться. 13. Так можно сказать.

**Дасгал 6.** Соедините 2 предложения в одно при помощи союзов *үл барам, барахгүй, байтугай*:

*үлгэр нь:*

*Би энэ номыг унших байтугай үзээгүй.*

Я эту книгу не только не читал, но и не видел.

*Би энэ шүлгийг уншихаар барахгүй цээжилчихсэн.*

Я эти стихи не только прочел, но и выучил наизусть.

*Машин техникээр үл барам бүтэн үйлдвэр ч худалдан авч болно.*

Можно купить не только машины и технику, но даже целое предприятие.

1. Би энэ үйлдвэрийг үзсэн. Би энэ үйлдвэрт ажиллаж байсан юм.
2. Манай аймгийн төвд дунд сургууль бий. Манай сумын төвд ч дунд сургууль бий.
3. Ноосыг машинаар тээвэрлэж болно. Үхэр тэргээр ч тээвэрлэж болно.
4. Хувьсгалаас өмнө Монголд том үйлдвэр байсангүй. Жижиг үйлдвэр ч бараг байсангүй.
5. Иванов Москвагаас ирсэн шүү. Хичээлдээ орчихсон.
6. Өвлийн цагт уулын ард хүйтэн байдаг. Уулсын өвөрт ч их хүйтэн байдаг.

**Дасгал 7.** Определите, что объединяет следующие слова:

тал, далай, дэлхий

газар, гадна, гадас, гарах

өвөр, өмнө, энд, одоо,

агаар, агуй, уул (агула), аажим, уудам тал (агудам).

**Дасгал 8.** Переведите названия некоторых государств, обратите внимание, какая особенность их объединяет:

Хөх Монгол, Шар уйгар, Цаст орон (Төвд), Энэтхэг, Солонгос, Ойрад, Зүүн гар, Дундад улс (Хятад).

**Дасгал 9.** Обратите внимание, как используются причастные (глагольные) формы для перевода таких понятий, как «Синее небо, белый пароход»:

Хөхрөн харагдах тэнгэрийн хаяа, цэнхэрлэн харагдана; цайран харагдах онгоц; талын чимэг болж харагдах гэрүүд; хадаг шиг цэнхэр, ус шиг цэнхэр.

## Улс ардын аж ахуй\*

Ардын хувьсгалын ачаар Монгол орон дан ганц хоцрогдсон мал аж ахуй орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болж хувирав. Улс ардын аж ахуйн үндсэн фонд 1924 онтой харьцуулахад 32 дахин өсөв. Хувьсгалын өмнөх Монгол оронд аж үйлдвэр зэрэг орчин үеийн эдийн засгийн салбар огт байгаагүй билээ. Харин одоо аж үйлдвэр тус орны улс ардын аж ахуйн шийдвэрлэх салбарын нэг боллоо. Ийнхүү улс ардын аж ахуйн хөгжил улам үйлдвэржих чиглэлтэй болж байгаа нь манай орныг ойрын ирээдүйд аж үйлдвэр хөдөө аж ахуйн орон болгоход тус дөхөмтэй юм.

Мал аж ахуй бол олон зууны турш монголын тал нутгийн хүн амын эрхэлдэг гол ажил байсан бөгөөд нэг талаар амьдралын хэрэгсэл, нөгөө талаар баяжих эх сурвалж байлаа. Монголчууд адуу, үхэр, тэмээ, хонь, ямааг таван хошуу мал гэдэг. Мөн түүнчлэн малаа халуун, хүйтэн хошуут мал буюу эсвэл урт богино хөлийн мал, нойтон өвсөнд дуртай, хуурай өвсөнд дуртай, мал гэх зэргээр дүрслэн нэрлэх дуртай.

Халуун хошуут мал гэдэг нь адуу хонь юм. Монголчууд эдгээр малыг илүү ойр гэж үздэг. Хүйтэн хошуут малд тэмээ, үхэр, ямаа орно. Хөлөөр нь нэрлэхдээ: богино хөлийн мал нь (хонь, ямаа, үхэр) малчны гэрээс холгүй таван км зайд бэлчдэг учраас голдуу эмэгтэйчүүд, хүүхдүүд бэлчдэг юм. Урт хөлийн мал (адуу, тэмээ) эзэнгүй хол явж бэлчдэг учраас эрэгтэйчүүд хариулна.

Монгол Улсын улс ардын аж ахуйн өөр нэг чухал салбар нь уул уурхай, түлш эрчим хүчний салбар мөн. Монгол орон алт, мөнгө, зэс, нүүрс, өнгөт металл, эрдэнийн чулуу зэрэг ашигт малтмалаар баян.

Монголын орчин үеийн шинжлэх ухаан 1922 онд Судар бичгийн хүрээлэн болж анх байгуулагдав. Монголын шинжлэх ухаан өнөөдөр математик, физик, хими, биологи, геологи, ботаник, газар зүй, түүх, философи, хэл зохиол зэрэг байгаль-нийгмийн ухаан үндсэн салбарт багтсан хэдэн арван хүрээлэн, үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний хүрээлэнтэй боллоо.

...онтой харьцуулахад — по сравнению с ...годом

32 дахин өсөв — выросло в 32 раза



тус дөхөм үзүүлэх, тус дөхөмтэй — способствовать  
буюу эсвэл — либо  
хүрээлэн болж байгуулагдав — создан как институт или Комитет...

## Дасгалууд

- Дасгал 10.** Переведите текст письменно.
- Дасгал 11.** Прослушайте текст, прочтите его вслух, в паузу постарайтесь перевести текст устно по фразам.
- Дасгал 12.** Разделите текст по смыслу на отрывки, дайте каждому фрагменту свое название. Определите, какой из отрывков наиболее информативен, какой несет другую нагрузку.
- Дасгал 13.** Проанализируйте первый абзац текста по смыслу, определите подтекст. Выскажите свое отношение к выражению «Ардын хувьсгалын ачаар...».
- Дасгал 14.** Расскажите устно по-русски все, что вы узнали о Монголии нового в последнее время. Изменилось ли ваше отношение к этой стране в процессе изучения монгольского языка по сравнению с прежним представлением о ней?
- Дасгал 15.** Придумайте десять уточняющих вопросов к тексту. Используйте вопросительные слова:  
хэзээ, хэдэн онд, хэдийд, хэн, юу, хаана, яагаад, яаж, хэдэн, аль, ямар?
- Дасгал 16.** Установите правильный перевод парных слов-терминов:  
орд газар, ашигт малтмал, аж ахуй, аж үйлдвэр, аж амьдрал, түүхий эд, эдийн засаг, уул уурхай, хэлхээ холбоо, нэхий дээл, орчин тойрон, байгаль хамгаалах, нутаг дэвсгэр, ходөө нутаг, зэвсэг хураах, байр суурь, арга хэмжээ, зах зээл, тусгаар тогтнол, бүс нутаг;  
независимость, хозяйство, уклад (жизненный уровень), сырье, месторождение, полезные ископаемые, территория, регион,

экономика, связи, дублинка, среда (окружающая среда), сельская местность, разоружение, рынок, мероприятия, средства (меры), промышленность, горная добыча, охрана природы, право, развитые страны, сотрудничество.

**Дасгал 17.** Найдите на карте Монголии города и аймачные центры. Перечислите все аймаки.

**Дасгал 18.** Восстановите текст, вместо точек вставьте слова, используя русский вариант:

### Тарвагны арьс тос

Манай эх орон агнуурын чиглэлийн амьтдын дотроос тарвага ... . Тарвагны арьс тос эх орны үйлдвэр, экспортын чухал түүхий эд бөгөөд ард түмэн дээр үеэс тарвагны амт сайтай мах өөхийг ... . мөн малын зарим өвчнийг анагаахад өргөн хэрэглэж ирлээ.

(занимает главное место; использует в пище)

**өөх** — жир;

**ангаах** — лечить;

**тос** — масло, жир;

**амт сайтай** — питательный;

**арьс** — кожа;

**агнуурын чиглэлийн амьтад** — промысловые животные.

**Дасгал 19.\*** Ответьте на вопросы:

1. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа Монгол оронд ямар өөрчлөлт гарсан бэ? (эдийн засгийн хувьд). 2. Улс ардын аж ахуйн ямар салбар илүү хөгжсөн бэ? 3. Монгол оронд одоо аж үйлдвэр хөдөө аж ахуйн ямар шинэ салбар бий болсон бэ? 4. Монгол улсын гол баялаг гэж юу вэ? 5. Монгол орон одоо хэдэн толгой малтай вэ? 6. 20 оноос хойшхи жилүүдэд хөдөө аж ахуйн ямар шинэ салбар бий болсон бэ? 7. Монгол орны мал аж ахуй ямар онцлоготой вэ? 8. Хавар, мал төллөх үед ямар байгалийн үзэгдэл аюултай вэ? (зуд). 9. Таван хушуу мал юу гэдэг вэ? 10. Яагаад монголчуудыг морьтон ард түмэн гэж нэрлэдэг вэ? 11. Мал аж ахуйн түүхий эдийг яаж ашигладаг вэ? 12. Монгол улс гаднаас юу юу импортлон авдаг вэ? 13. Монгол улс гадаадад юу гаргадаг вэ? 14. Монгол оронд дэлхийд алдартай хөнгөн үйлдвэрийн ямар бүтээгдэхүүн гаргадаг вэ?

15. Томоохон уул уурхайнууд хаана байдаг вэ? 16. Эрдэнэт хотны учир юу вэ? 17. Монгол орны хөсөг тээвэр ямар төрөлтэй байдаг вэ? (железные дороги, самолет, шоссейные дороги). 18. Монгол орны гол гол ашигт малтмалыг хэлэх үү?

**Дасгал 20.** Переведите с русского языка на монгольский:

1. Монголия — горная страна. 2. Горы преобладают в Западной, а равнины — в Восточной Монголии. 3. Недра (газар хөрс) Монголии богаты полезными ископаемыми. 4. Климат Монголии определяется ее географическим положением. 5. Значительная часть населения Монголии живет в городах. 6. Высший орган государственной власти Монголии — Великий Государственный Хурал. Глава государства — Президент. 7. Исполнительные функции осуществляет Совет министров. 8. Кочевое животноводство, долго остававшееся основным занятием населения, придало своеобразный характер всему жизненному укладу монголов. 9. Промышленность, созданная почти заново, базируется на местных источниках сырья и энергии. 10. Большое развитие получила промышленность строительных материалов.

**Дасгал 21.** Переведите поговорку, определите, о чем она:

*Унасан газар, угаасан ус.*

**Дасгал 22.** Выпишите в четыре колонки названия животных, особенно характерных для указанных ниже местностей:

тэмээ, сарлаг, буга, ямаа (янгир ямаа), адуу, хулан, үнэг, чоно, тарвага, зээр, гөрөөс, барс, ирвис, баавгай

Хангай

Говь

Тал

Алтай

**Дасгал 23.** Определите, какое из животных лишнее и почему:

муур, хулгана, үхэр, луу, тахиа, бичин, морь, тэмээ, заан, арслан, барс, гахай, нохой, туулай, могой, хонь.

Та ямар жилтэй вэ?

**Дасгал 24.** Отгадайте загадку:

*Тэр орны цаасан дээр энэ орны ном бичнэ<sup>1</sup>.*

---

<sup>1</sup> снег

## ЯРИАНУУД\*

- Та Улаанбаатарын арьс ширний үйлдвэрийг үзсэн үү?
- Үзэхээр барах уу, би тэнд ажиллаж байсан юм. Намайг тэнд ажиллаж байхад энэ үйлдвэр чинь аж үйлдвэрийн комбинатын нэг хэсэг байсан юм. Одоо орчин үеийн техникээр тоноглогдсон том үйлдвэр болжээ.
- Энэ үйлдвэрт юу юу хийдэг юм бэ?
- Энд хонь, ямааны арьс, үхэр, адууны ширийг олон дамжлага дамжуулан боловсруулж янз бүрийн бүтээгдхүүн гаргадаг юм.
- Түүхий эдээ хаанаас авах вэ?
- Хөдөө, аймгуудаас авдаг юм. Мах комбинатаас ч бас малын арьс шир авдаг.

\* \* \*

- Чиний эгч хивсний үйлдвэрт ажилладаг байх аа?
- Үгүй, больсон. Нэхмэлийн үйлдвэрт шилжсэн шүү дээ! Тэнд нэхэх суурь машин дээр ажилладаг юм.
- Нэхмэлийн үйлдвэр олон ажилчинтай юу?
- Их олон ажилчинтай. Гурван ээлжээр ажилладаг юм. Эгч заримдаа өдрийн ээлжинд, заримдаа шөнийн ээлжинд явдаг.
- Чи эгчээрээ үйлдвэрийн нь тухай яриулсан уу?
- Яриулахаар үл барам, өөрөө ч очиж үзсэн.
- Чамд нэхмэлийн үйлдвэр ямар санагдав?
- Их сайхан санагдсан.

\* \* \*

- Уучлаарай. Та энэ үйлдвэрийн дарга уу?
- Тийм ээ. Би энэ үйлдвэрийн дарга.
- Та завтай бол үйлдвэрийнхээ тухай бидэнд товчхон ярьж өгөөч.
- Бололгүй яахав! Манай үйлдвэр... анх байгуулагдахдаа 200-аад ажилчинтай жижигхэн үйлдвэр байсан юм. Одоо 2 мянга гаруй ажилчинтай том үйлдвэр болоод байна. Гаргадаг бүтээгдхүүн нь ч их нэмэгдлээ. Манай үйлдвэр ноосны үйлдвэрт цэвэрлэж боловсруулсан ноосоор янз бүрийн даавуу

нэхэж заримы нь гадаадад гаргадаг, заримы нь худалдаанд шилжүүлдэг.

— Танд их баярлалаа.

**Дасгал 25.** Тема «Буддизм». Переведите на слух. Возьмите интервью у участника конференции:

### **Азийн буддистуудын бага хурал\***

*Ханой.* Азийн буддистуудын энх тайвны бага хурлын зэвсэг хураах комиссын уулзалт «Цөмийн зэвсгийг бүрэн устгая, бүх ард түмний энх тайван бүрэн эрхийн төлөө» уриан дор Ханойд нээгдэв.

Уулзалтад Япон, Вьетнам, Балба, Орос, Монгол, Тайланд, Лаос, Шри-Ланк, Солонгосын буддын шашны сүм хийдийн 67 төлөөлөгч оролцож байна.

**Дасгал 26.** Запомните названия аймаков Монголии:

<b>аймак</b>	<b>народы</b>	<b>столица</b>
Архангай	халха	Цэцэрлэг
Өвөрхангай	халха	Арвайхээр
Баянхонгор	халха	Баянхонгор
Булган	халха	Булган
Баян-Өлгий	казахи	Өлгий (Ульгий)
Говьалтай	халха	Алтай
Дорноговь	халха	Сайншанд
Өмнөговь	халха, харчин	Даланзадагад
Дорнод	буряты, халха, үзэмчин	Чойбалсан
Дундговь	халха, харчин	Мандалговь
Завхан	халха	Улиастай
Сэлэнгэ	буряты	Сүхбаатар (Сухэ-Батор)
Төв	халха	Зуун мод
Сүхбаатарын	дариганга	Баруун урт
Увс	байты, дөрвөд, үзэмчин	Улаангом
Ховд	мянгат, үзэмчин, захчин	Ховд (Кобдо)
Хэнтий	буряты, халха	Өндөрхан (Ундурхан)
Хөвсгөл	халха, торгуут, үзэмчин	Мөрөн (Мурэн)

**Дасгал 27.** Выберите тему для устного рассказа:

1. Природа Монголии.
2. Народное хозяйство: животноводство, промышленность.
3. Города Монголии.

## **ХЯНАЛТЫН АЖИЛ**

**I.** Переведите с монгольского языка на русский:

### **Токиогийн уулзалт амжилттай дуусав\***

Ерөнхий сайд Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал дээр **МОНЦАМЭ** агентлагийн сурвалжлагчийн асуултад хариулахдаа, бид Япон улсын ерөнхий сайд, албаны бусад хүмүүстэй уулзаж, монголыг дэмжигч орнуудын Токиогийн хоёрдугаар зөвлөлгөөнд оролцоод ирлээ. Монголыг дэмжигч орнуудын зөвлөлгөөн уламжлалт чанартай болж байгаа нь олон улсын хамтын нийгэмлэг ардчилал, шинэчлэлийн үйл явцыг дэмжих дэмжлэг нь улам бүр зохион байгуулалттай, нэгдсэн чиг бодлоготой болж байгаагийн илрэл юм.

Токиогийн уулзалт их амжилттай боллоо. Уулзалтыг Японы Засгийн газар, Дэлхийн банк зохион байгуулж хийлгэлээ. Ирэх 18 сард Монгол улсад нийтдээ 320 сая долларын тусламж, хөнгөлөлттэй зээл олгох боллоо. Энэ онд 75 сая доллар, 1993 онд үлдсэн хэсгийг олгохоор тохиролцлоо.

Монголыг дэмжигч орнуудын монголын ард түмний зүрх сэтгэлээсээ хийж байгаа өөрчлөлт шинэчлэлийн үйл явцыг ойлгож, дэмжиж манай улсын болон олон улсын хувьд ач холбогдолтой болохыг үнэлж байгаа нь тод харагдлаа. Токиогийн уулзалтад 17 орон, олон улсын томоохон байгууллагууд оролцлоо. Энэ уулзалтын онцлог нь монгол орны өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцын шилжилтийн үетэй холбоотой юм. Урьд бид дэмжигч орнуудаасаа яаралтай тусламж авч, гадаад худалдааны балансыг тэнцвэржүүлж байсан. Ирэх оноос бид авах тусламж дэмжлэгээ гол төлөв эдийн засгийнхаа хөгжлийн шинэ үндсийг бүрдүүлэхэд зориулсан төслийг санхүүжүүлэх болно.

Монголыг дэмжигч орнууд, олон улсын эдийн засгийн байгууллагууд Монголд туслахаар хувь, хандив амаллаа. Япон

улс 75 сая долларын тусламж зээл олгохоос 28 сая нь буцалтгүй тусламж, мөн 50 сая доллартай тэнцэх иенийн хөнгөлөлттэй зээл юм.

Эдгээр тусламжийг ойрын хоёр жилд түлш, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах, хүнсний зүйлээр өөрийгөө хангах чадвартай болгох зорилгоор хөдөө аж ахуйгаа дэмжих, экспортын үйлвэрлэлийг тэтгэх, хөдөө аж ахуйн тээврийн салбарт техникийн шинэчлэл хийх зэрэг дөрвөн гол чиглэлд зарцуулах юм. Мөн үр ашигтай жижиг үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд анхаарах ёстой. Энэ оны хувьд үйлдвэрлэлийнхээ тогтвортой ажиллагааг хангахын зэрэгцээ, хүн ардын зайлшгүй чухал хэрэгцээтэй бараа таваараар хангахад анхаарна. Тусламж дэмжлэгийг бид аль болох үр ашигтай ашиглахын тулд нэгдсэн чиг бодлоготой ажиллах болно. Ирэх есдүгээр сард Улаанбаатар хотноо болох Монголыг дэмжигч орнуудын зөвлөлгөөнд төслийн санхүүжилтийн талаар ярилцах болно гэв.

## II. Переведите с русского на монгольский язык:

1. Основной отраслью экономики Монголии было и остается сельское хозяйство, в том числе животноводство. Наряду с обеспечением населения продовольствием, сельское хозяйство дает основное сырье для нашей промышленности. Сельскохозяйственная продукция составляет большую часть экспорта.

2. В основном Монголия экспортирует продукцию легкой, пищевой и горнодобывающей промышленности.

3. Предприятия легкой промышленности Монголии перерабатывают традиционные виды животноводческого сырья — кожу, шерсть, пух, мясо, кости.

4. С переходом к отгонно-кочевому (пастбищному) животноводству и развитием новых отраслей народного хозяйства жизнь монгольского народа все больше приобретает оседлый характер.

5. Большое значение приобретает город Дархан, расположенный у железной дороги к северу от Улан-Батора. Это развивающийся промышленный центр с быстро растущим населением.

6. Внешнеэкономические связи Монголии с каждым годом расширяются и крепнут.

7. Монгольский язык в нашей стране существенно отличается от языка тех монголов, которые проживают в других странах, среди других народов.

## Үг хэллэг

газар зүй — география  
эрх зүй — право  
үзэглэх — парафировать  
батлах — ратифицировать  
Балба — Непал  
Солонгос — Корея  
аж ахуй — хозяйство  
улс ардын аж ахуй — народное  
    хозяйство  
хөдөө аж ахуй — сельское хо-  
    зяйство  
мал аж ахуй — животноводство  
аж амьдрал — жизненный уро-  
    вень, образ жизни  
аж үйлдвэр — промышлен-  
    ность;  
    үйлдвэр — предприятие,  
    фабрика, завод  
үйлдвэрлэл — производство,  
    үйлс — дело, деяния  
эрдэм шинжилгээ — исследо-  
    вание  
салбар — отрасль  
уур уурхай — горная добыча  
ашигт малтмал — полезные ис-  
    копаемые  
хөнгөн хүнсний үйлдвэр —  
    легкая и пищевая про-  
    мышленность  
түүхий эд — сырье  
хошуу — нос, морда;  
    таван хошуу мал — пять ви-  
    дов скота  
онцгой — особый  
ан агнах — охотиться;

анчин — охотник;  
ан гөрөө — дичь  
адуу — лошадь (биол.);  
морь — конь  
тэмээ — верблюды  
хонь — овца  
ямаа — коза;  
    янгир ямаа — горный баран  
үхэр — бык;  
    үнээ — корова  
гүү — кобылица  
чоно — волк  
буга — олень  
барс — тигр  
баавгай — медведь  
хулан — кулан  
сарлаг — як  
үнэг — лиса  
туулай — заяц, кролик  
луу — дракон  
бичин — обезьяна  
нохой — собака  
гахай — свинья  
хулгана — мышь  
тахиа — петух, курица  
учрах — встречаться  
монгол судлалын холбоо — ас-  
    социация монголоведов  
муур — кошка  
тарвага — тарбаган  
бэлчих — пастись;  
    бэлчээр — пастбище  
бэлчээрийн мал аж ахуй — па-  
    стбищное скотоводство  
нүүх — кочевать;



нүүдэл — кочевье;  
 нүүдлийн аж ахуй — коче-  
 вое хозяйство  
 Судар бичгийн хүрээлэн — Ко-  
 митет по науке (судар би-  
 чиг — рукопись)  
 эзэнт гүрэн хаант улс — мо-  
 нархия  
 тусгаар тогтнол — независи-  
 мость

ёс заншил — обычаи, традиции  
 боловсруулах — перерабаты-  
 вать;  
 боловсронгуй болгох — со-  
 вершенствовать  
 хандивлагч орнуудын  
 зөвлөлгөөн — совещание  
 стран-доноров  
 олонхи, ихэнх — большинство  
 цөөнх — меньшинство

## АЙМАКИ

Аймак (аймаг) — административная единица Монголии. В настоящее время насчитывается 21 аймак<sup>1</sup>.

Монгольское название	Перевод	Центр	Русское
1 Архангай	Архангайский	Цэцэрлэг	Цэцэрлэг
2 Баянхонгор	Баянхонгорский	Баянхонгор	Баянхонгор
3 Баян-Өлгий	Баян-Ульгийский	Өлгий	Ульгий
4 Булган	Булганский	Булган	Булган
5 Говь-Алтай	Гоби-Алтайский	Алтай	Алтай
6 Дорноговь	Восточногобийский	Сайншанд	Сайншанд
7 Дорнод	Восточный	Чойбалсан	Чойбалсан
8 Дундговь	Среднегобийский	Мандалговь	Мандалговь
9 Дархан-Уул	Дархан-Ульский	Дархан	Дархан
10 Завхан	Завханский	Улиастай	Улясутай
11 Ховд	Кобдосский	Ховд	Кобдо
12 Орхон	Орхонский	Эрдэнэт	Эрдэнэт
13 Өвөрхангай	Увурхангайский	Арвайхээр	Арвайхээр
14 Өмнөговь	Южногобийский	Даландзадагад	Даландзадагад
15 Сумбэр-Уул	Сумбэр-Ульский	Чойр	Чойр
16 Сухбаатар	Сухэ-Баторский	Баруунурт	Баруунурт
17 Сэлэнгэ	Селенгинский	Сухбаатар	Сухэ-Батор
18 Увснуур	Увсунурский	Улаангом	Улангом
19 Төв	Центральный	Зуун мод	Зуун мод
20 Хөвсгөл	Хубсугульский	Мөрөн	Мурэн
21 Хэнтий	Хэнтийский	Өндөрхан	Ундурхан

<sup>1</sup> До революции 1921 года в Монголии существовало 4 аймака: Сайн ноён хаан, Цэцэн хаан, Засагт хаан, Тушээт хаан.

## СОКРОВЕННОЕ СКАЗАНИЕ

### ГРАММАТИКА

#### I. Выражение временных отношений в предложении:

1. Предварительное деепричастие: *-магц* (как только). Например:

**Миний аав хотод ирмэгц чи түүнтэй уулзаарай.**

— Как только мой отец приедет в город, ты встреться с ним.

2. Последовательное деепричастие: *-хлаар* (в то время, как; после того, как). Например:

**Сэрүүн орохлоор хонио бэлчээрт гаргах юм.**

— После того, как наступает прохлада, овец выводят на пастбище.

3. Причастие с послелогоми: *хойш, хойно, дараа, нааш, өмнө, турш*. См. таблицу в Приложении.

4. Причастие в дательном падеже.

**Намайг ирэхэд...**

Когда я пришел...

#### II. Аналитические конструкции:

1. Модальные: *-вал зохино*. Например:

**Энэ номыг уншвал зохино.**

— Эту книгу необходимо прочитать.

2. Длительный вид: *-ж ирсэн (-саар ирсэн)*. Например:

**Манай хоёр орны харилцаа бэхжсээр ирсэн.**

— Отношения между нашим странами всегда укреплялись и продолжают укрепляться.

## **ПРАКТИЧЕСКАЯ ГРАММАТИКА**

**Дасгал 1.\*** Переведите с монгольского языка на русский предложения, в которых использованы причастия с послелогоми:

1. Хичээл эхэлснээс хойш хоёр сар боллоо. 2. Тэр айлд ойртох тутам улам олон мал харагдлаа. 3. Их орой болсон хойно тэр хоёр уулзав. 4. Тэр хөгжимчин морин хуур сайхан дардгаас гадна ятга хөгжмөөр чадмаг тоглодог. 5. Тэд их хурлын ажилд оролцохын зэрэг хот орж их юм үзэжээ. 6. Хэн боловч их сургуульд орохын тулд чармайж зүтгэх ёстой. 7. Засгийн газраас заасны дагуу энэ нутагт шинэ үйлдвэр барих болжээ.

**Дасгал 2.** Составьте предложения с использованием субстантивированных причастий:

монгол хүн зохиосон нь, ...200 жилийн ойг ёслон тэмдэглэх нь, энх тайванч бодлого явуулах нь, энэ үйлдвэрийг ашиглалтад оруулсан нь, тус орны ерөнхийлөгч манай оронд айлчилж байгаа нь.

**Дасгал 3.** Дополните предложения, используя данные ниже окончания фраз:

Аяны урт зам баруун урд зүгийг цааш цаашилсаар...

Би энд ирээд...

Гэрт орохоосоо өмнө...

Цэрэгт явахынхаа урьд би...

Ард гүмэнд эрхэм сайн үйлчлэхийн тулд...

...бүгдэд тэгш хариуцлага хүлээлгэх хууль хэрэгтэй.

...хоёр жил ахындаа суудаг байлаа.

...би хонь хариулж байлаа.

...говийн тал руу одно.

...хэдэн үг хэлэх санаатай.

## Хөх Монголын хөлгөн судар\*

«Рамаяна», «Шицзин», «Роландын дуулал», «Игорийн цэрэглэсэн тууж»... Хүн төрөлхтөний бүтээсэн ном зохиолын мөнхийн алдарт оргилуудын дунд сүндэрлэн байгаа «Монголын нууц товчоо» хэмээх нэгэн сүрлэг оргил монголчуудын бидний чухамхүү үндэсний бахархал мөн.

«Нууц товчоо» бол монгол түмний ахуй байдал, ёс заншил, түүх, соёл цэргийн эрдэм, уран зохиолын нэвтэрхий толь билээ. «Ном бүхэн өөрийн хувь заяатай байдаг» гэсэн латины зүйр үг бий. «Нууц товчооны хувь заяаг сонирхож үзвэл үнэхээр гайхалтай. Хэн зохиосон, монгол эх нь хаана байна вэ гэх зэрэг «Нууц товчооны» хувь тавилантай холбоотой олон нууц бий.

Оросын эрдэмт лам, архимандрит Палладий (жинхэнэ овог нэр нь П. И. Кафаров) гэгч «Чингис хааны тухай эртний монгол домог үг» зохиолоо Бээжин дэх Оросын шашны төлөөлөгчдийн газрын бүтээлүүдэд 1866 онд нийтэлсэн байна. «Монголын нууц товчоо» бол монгол хэлээр хятад бичгээр бичигдэж үлдсэн юм.

Академич Ц. Дамдинсүрэнгийн тэмдэглэсэнчлэн «Нууц товчоог» түүхт явдал нь болсон монгол газарт тэр явдал оролцсон монгол хүн зохиосон нь их баттай үнэмшилтэй зүйл юм». «Нууц товчооны» эцэст 1240 онд бичиж дуусгав гэж бичсэн байдаг юм. Чингис хааны хамаг монголыг нэгтгэж, нэгдсэн монгол улсыг байгуулсан сүүлийн хагас зуун жилийн явдлыг он дараалан товчоолон тэмдэглэж өгүүлсэн юм.

«Нууц товчоонд» Монгол овогтныг нэгтгэн Монголын нэгдсэн улсыг байгуулахын төлөө Тэмүүжин Чингис хааны тэмцсэн түүхийг гуч гаруй тусгай өгүүллэг болгон уран зохиолын аргаар дүрслэн өгүүлсэн юм. «Монголын нууц товчооны» эхийн тийм нэг тусгай өгүүлэмж бол Дува-сохор, Добу-мэргэн хоёрын тухай өгүүлэмж болно. Дува-сохор манлай дундаа гагц нүдэт гурван нүүдлийн газраа харах билээ» гэсэн өгүүлбэрээр эхэлж «нэгэн өдөр Дува-сохор Добу-мэргэн дүүтэйгээ Бурхан-халдун дээр гарав. Дува-сохор Бурхан-халдун дээрээс харж Түнхлэг горхин уруу нэгэн бүлэг иргэн нүүж ирэхийг үзэж тэдний дотор сайхан охин сууж явааг үзэж хүнд өгөөгүй бол Добу-мэргэн чамд гуйя гэж Добу-мэргэн дүүгээ үзүүлэхээр илгээв. Добу-мэргэн очиж үзвэл үнэхээр гуа сайхан болоод эрд өгөөгүй охин байсан тул түүнийг Добу-мэргэнд авч өгсөн тухай өгүүлнэ».

Саруул ухаанаас илүү  
Сайн нөхөр байдаггүй  
Мунхаг хилэнгээс илүү  
Муу дайсан байдаггүй (Чингис-хан)

## Дасгалууд

**Дасгал 4.\*** Ответьте на вопросы по тексту сначала по-русски, а затем по-монгольски:

1. «Монголын нууц товчоо» дэлхийн ямар бүтээлүүдтэй эн зэрэгцүүлж болох вэ? 2. «Монголын нууц товчоо» хэдэн онд бичиж дуусгасан бэ? 3. «Нууц товчоог» анх олсон эрдэмтний алдар нэр хэн гэдэг вэ? 4. Тэр «Нууц товчоог» ямар нэрээр нь нийтэлсэн бэ? Ямар бүтээлд нийтэлсэн? 5. «Нууц товчоог» ямар хүн зохисон бол доо? 6. «Монголын нууц товчооны» гол баатар хэн бэ? 7. «Монголын нууц товчооны» гол санааг товчхон ярих уу? 8. «Нууц товчооны» гол гол явдлыг ямар аргаар дүрсэлсэн бэ? 9. Дува-сохорын тухай өгүүлэмжийн учир юу вэ? 10. Дува-сохор гэгч хүн чухамхүү ямар хүн байв? 11. «Нууц товчоонд» үнэн түүхийг дүрсэлсэн гэж үзэж болох уу? 12. Яагаад «Нууц товчоог» уран зохиолын дурсгалт бичиг гэж үздэг вэ? 13. «Нууц товчоонд» дотрох хэдэн өгүүлэмжийн сэдвийг хэлэх үү? 14. Тэмүүжин Монгол улсын түүхэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? 15. Тэмүүжин хэдэн онд Чингис-хаан гэж өргөмжлөгдсөн бэ? 16. Чингис-хааны үеийн дараахь Монгол гүрний хувь заяаны талаар товчхон ярих уу? 17. Яагаад Европд монголчуудыг XIV-р зууны татарууд гэж нэрлэсэн бэ?

**Дасгал 5.** Составьте тезисный рассказ по тексту «Хөх Монголын хөлгөн судар» по-русски.

**Дасгал 6.** Найдите в тексте монгольский эквивалент следующих выражений:

национальная гордость, величественно возвышается среди вершин мировой литературы, со своей судьбой, поистине удивительна, монгольский оригинал, латинская пословица, энциклопедия, древняя монгольская легенда, связана с судьбой, как отмечал академик Ц. Дамдинсурэжн, подлинно, достойно

доверия, объединение всех монголов, написано по-монгольски китайским письмом, исторические события, создание единого монгольского государства.

**Дасгал 7.\*** Переведите с монгольского языка на русский:

Монголын төдийгүй дэлхийн соёлд түүх уран зохиолын ач холбогдолтой «Монголын нууц товчооны» 750 жилийн ойг ёслол тэмдэглэх нь соёлыг хөгжүүлэх дэлхий дахины арван жилийн хүрээнд Монгол улсаас зохион байгуулах нэг том арга хэмжээ болно гэж үзэж байна.

1987 онд Улаанбаатарт болсон монголч эрдэмтдийн олон улсын тавдугаар их хуралд оролцогчид түүх, уран зохиол, соёлын их ач холбогдолтой энэхүү хосгүй бүтээлийн түүхт ойг олон улсын хэмжээнд өргөн тэмдэглэх тухай үзэл санааг санал нэгтэй дэмжсэн.

**Дасгал 8.** Переведите с монгольского языка словосочетания, проследите за разными значениями однокоренных слов *нэг, нэгдэх, нэгтгэх, нэгтэй, нэгдэл, нэгдсэн*:

олны нэг, нэгэн өдөр, нэгэн бүлэг иргэн нүүж ирнэ, санал нэгтэй, хамаг монголыг нэгтгэхийн төлөө тэмцэл, хэн нэгэн хүн, нэгдсэн улс байгуулах, хөдөө аж ахуйн нэгдэл, ажилчны нэгдсэн нам, орон бүхний пролетари нар нэгдэгтүн! НУБ, АНУ

**Дасгал 9.** Переведите монгольскую поговорку, вошедшую в «Сокровенное сказание монголов»:

*Энэ бие хэврэг боловч  
Эрхэм нэр мөнх шүү.*

**Дасгал 10.** Отгадайте загадки<sup>1</sup>:

1. *Нүдгүй байж уйлдаг, хөлгүй байж явдаг.*
2. *Толгой нь биеийн дайсан.*

**Дасгал 11.** Объясните разницу в значениях временных конструкций, составьте с ними предложения:

явна, явах юм, явах юм байна, явах болно, явж байна, яваа, явлаа, явжээ, яваагүй, явсан, явж байсан, явдаг байсан, явах

---

<sup>1</sup> Ответ в конце урока

болсон. явахаар болсон, яваад байна, явсаар байна, явж үзээгүй, амьд явахын учир, явдаг, явах байсан, явах юмсан.

**Дасгал 12.** Переведите на монгольский язык, используя глагол **явах** или **явуулах** в разных значениях:

1. Мои часы идут правильно. 2. В столице проходит конгресс. 3. Мой отец сейчас в другом городе, в командировке. 4. Правительство намерено провести меры по развитию сельского хозяйства. 5. Живой человек напьется из золотой чаши. 6. Завтра мне надо ехать. 7. Ну, я пошел. 8. Мой брат служил в армии. 9. Моя сестра ходит в школу. 10. Можно с вами отправить письмо одному знакомому?

**Дасгал 13.** Сравните перевод пословиц, дополните в оригинале нужное слово, следуя переводу:

Авах хүнд нэг үг ч эрдэнэ	Для берущего и одно слово драгоценность
Орхих хүнд ... ч улиг	Для бросающего и <i>тысяча поучений</i> пустое
Ураг садны хол нь дээр	Родственники лучше — когда далеко
Ус цасны ... дээр	Вода — когда <i>близко</i>
Хэлэхэд амар	Легко сказать,
... хэцүү	да трудно <i>сделать</i>
Гэнэгийн гарт эрх мэдэл аюултай	В руках глупого власть опасна
... ирт мэс аюултай	<i>В руках ребенка</i> острый меч опасен

**Дасгал 14.** Переведите устно с русского языка на монгольский отрицательные предложения:

1. Эти две девушки не студентки. 2. Мой брат не инженер. 3. В этой комнате нет цветного ковра. 4. На стене нет карты. 5. Эти два ученика не любят заниматься языком. 6. На столе нет книги. 7. Они не крестьяне. 8. Это неправда. 9. Я не хотел этого сказать. 10. Вы разве не служащие? 11. Этот урок нетрудный. 12. Это нелегкая работа. 13. В этой стране нет крупных заводов.

14. В домах этих крестьян нет электричества. 15. На столе нет черного хлеба. 16. В комнате нет мягкого кресла. 17. В нашей поликлинике нет детского врача. 18. Некому перевести этот текст. 19. У меня нет свободного времени. 20. У него нет детей.

Дасгал 15.\* Переведите на слух:

### Нохойноос үүссэн (болсон) дайн

1925 онд нэгэн грек цэргийн нохой хил давж Болгарын нутагт оров. Тэр цэрэг нохойгоо хөөж хойноос нь орсонд Болгарын харуулын цэрэг буудаж алжээ. Үүнээс болж Грекийн цэргүүд Болгарт түрэн орж 48 болгар хүнийг алж шархдуулав. Болгар улс даяар үүнд хилэгнэн зөрчил улам хурцадсанд олон улсын холбоо яаралтай хурал хийж эвлэрүүлснээс хоёр тал эвлэрэхийг зөвшөөрч Болгар 30 сая зоосны төлбөр өгчээ.

### ЯРИАНУУД\*

#### *Улаанбаатараар явсан нь*

Тэр гурав их сургууль дээрээс гараад тэргэнд сууж баруун тийш хөдлөв.

*Робинсон:* — Ингэхэд бид хаачих гэж байгаа билээ?

*Нансалмаа:* — Хот үзнэ гэсэн биз дээ ноёнтоон?

*Робинсон:* — Аа, тэгэлгүй яахав. Өнөөдөр сайхан ч өдөр болох нь. Ёстой л гадаа явж баймаар өдөр байна даа.

*Нансалмаа:* — Эхлээд бид хотын томоохон барилга, гудамжны талаар мэдлэгтэй больё сүүлд нь өндөр уулын дээрээс хот руу харна.

*Робинсон:* — Тийм, тийм. Би ч бас тэгж бодоод байсан.

*Нансалмаа:* — Одоо бид Энх тайвны гудамжаар явж байна. Улаанбаатарын хамгийн урт, өргөн гол гудамж. Замын хойт талд Улсын их дэлгүүр, өмнө талд Орос улсын элчин сайдын яамны барилга. Эргэн тойрон нь бүгд орон сууц. Их дэлгүүрээс зүүнтэйх хэсгийг «Дөчин мянгат», баруунтайхыг нь «Тавин мянгат» гэж хотынхон нэрлэдэг юм.

*Робинсон:* — Тэр «дөчин мянга», «тавин мянга» гэдэг тоо чинь юу гэсэн үг вэ?



*Нансалмаа:* — Уг нь 40 000 дөрвөлжин метр талбай бүхий орон сууц гэсэн үг юм даа. Товчхондоо «дөчин мянгат», «тавин мянгат» гэж заншсан юм.

*Робинсон:* — Мөн, мөн. Мэдэж авлаа. Энэ урд харагдаж байгаа хачин бөмбөгөр барилга тань юу юм бэ?

*Нансалмаа:* — Аа, энэ циркийн шинэ барилга.

Тэгээд тэр гурвын суусан тэрэг Богд уулын Зайсан толгойд гарч зогсов. Тэд нар тэрэгнээс гарав.

*Робинсон:* — Юутай гайхамшиг, өндөр өндөр уулс, битүү хөвч, их хот, гол мөрөн, цэлийсэн тал, хөх тэнгэр ...

Улаанбаатар чинь баруунаасаа зүүн тийш үргэлжилсэн урт хот юм байна даа. Нөгөөх дөрвөн уул чинь аль аль билээ, Нансалмаа?

— Тэр хойт өндөр уулыг Чингэлтэй гэдэг, тэр баруунтай Сонгино хайрхан, зүүнтэй Баянзүрх уул, энэ Богд уул далайн төвшнөөс дээш 3 000-аад м. Ингээд дөрөв.

— Та баруун тийш харагтун, юу юу харагдаж байна?

— Телевизийн цамхаг. Тэр нэг их өндөр Буддын сүм, алтан оройтой, Гандантэгчинлэн хийд мөн бололтой.

— Тиймээ, та яг зөв хэллээ. Бид дараа тэнд очих болно. Тэр өндөр сүмийг тань «Өндөр Жанрайсаг» гэдэг юм.

— Жанрайсаг гэдэг чинь Авалокитешварын төвд нэр гэдэг бил үү? Монгол нэр нь юу юм бол?

— «Нүдээр үзэгч» гэсэн үг гэж би дуулсан юм шиг байна. Сайн мэдэхгүй юм даа.

— Хараач! Энэ нэг сонин хөшөө байна. Яасан үзэсгэлэнтэй юм бэ!

— Зөвлөлт цэргийн дурсгалын хөшөө. Тэр дугуй хана шиг хэлбэртэй юм нь монголчуудын гал голомт (тулга) юм. Ингээд зөвлөлтийн баатар улаан цэрэг, монголчуудын гал голомтыг удаа дараа сахин хамгаалж ирсэн түүхийг бэлэгдэн үзүүлсэн хөшөө юм.

— Тун ч сүрлэг, мөн ч уран барьсан утга төгс хөшөө байна даа.

— Энүүхэн дор, голын хойхон эрэгт байгаа олон сүм тань бас нэг хийд үү?

— Биш ээ, тэр Богд хааны ордон музей. Бидний дараа үзэх газар.

— Хүний гар хүрээгүй, Монголын ариун сувд — Богд уул минь, Таны нууцлаг, сүрлэг сайхан үзэсгэлэнг харахад ханашгүйээ! гэж оросын их эрдэмтэн — жуулчин Козловын бичсэн санаанд орж ирээд байна.

— Дэлхийн хамгийн эртний дархан цаазат газрын нэг — энэ сайхан уулын ариун агаар амьсгалахад сайхан!

— Улаанбаатар хир эртний хот вэ?

— 1749 оноос түүхтэй. Эхлээд бурхан шашны хийд байсан. Хожим нь өргөжсөөр «Их Хүрээ», «Да Хүрээ», «Богдын Хүрээ», «Нийслэл Хүрээ» нэрийг авч, 1924 оноос Улаанбаатар гэдэг болсон юм.

**Дасгал 16.\*** Переведите выражения, уделяя внимание частицам, придающим тот или иной эмоциональный оттенок высказыванию:

1. Яасан үзэсгэлэнтэй газар вэ! 2. Харалгүй яахав! 3. Та хот үзнэ гэсэн биз дээ? 4. Сайн мэдэхгүй юм даа. 5. Монгол нэр юу юм бол? 6. Нөгөөх дөрвон уул чинь аль аль билээ? 7. Төвд нэр гэдэг билүү?

**Дасгал 17.** Переведите с русского языка на монгольский:

1. Какой прекрасный город! 2. Что это за странное здание впереди? 3. Город, с четырех сторон окруженный горами. 4. Да, да, я тоже так думал. 5. Да, конечно, как же иначе! 6. Итак, куда мы направляемся? 7. Сегодня замечательный день. 8. Да, да, я понял. 9. Что значат эти цифры? 10. Величественный, красивый, с глубоким смыслом мемориал.

**Дасгал 18.\*** Переведите анекдоты на слух:

**I.** Нэг анчин:

— Би Африкт байхдаа тэндээс бар алсан гэж ярьлаа.

— Харин Африкт бар байдаггүй юм гэхэд, анчин:

— Ёстой үнэн, би бүх бары нь алчихсан юм гэжээ.

**II.** Хоёр хүүхэд ярьсан нь:

— Миний ээж багшсан бол сайхан дэвтэртэй, үзэгтэй байхсан.

Чиний ээж багш байтал чи яагаад дэвтэр байтугай үзэг ч гүй байдаг юм бэ?

— Тэгвэл чиний ээж шүдний эмч байтал дүү чинь яагаад шүдгүй байгаа юм бэ?

III. Хоёр баян хүн ярьсан нь:

— Танайх манайхаас баян юм.

— Яагаад? Манайх ч мянган хоньтой, танайх ч.

— Танай хонь мянга, манай хонь мянгахан шүү дээ!

Дасгал 19. Переведите с монгольского на русский:

### Улсын түүхийг л бичиж байна

*Монголын төр, улс байгуулагдсаны 800 жилийн ойг 2006 онд хэрхэн тэмдэглэх бол? Төр, засгаас энэ талаар одооноос бодож, төлөвлөж буй юм бий болов уу?*

*Өндөр настан А. Далай. Сухбаатар дүрэг*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас энэ талаар лавлахад одоогоор бодож төлөвлөсөн юм үгүй бололтой. Төр, засгийн байгууллагууд 2000 оныг хэрхэн угтах тухай л голлон ярьж байгаагаас Монгол Улсынхаа 800 жилийн ойг одоохондоо төдийлөн анхаараагүй байгаа юм уу даа гэх бодол төрлөө. Гэхдээ Ерөнхийлөгч Н. Багабандийн зарлигаар Монголын түүхийг эрдэмтэд таван ботиор шинэчлэн бичиж байна.

Өнөөдөр 26.07.99.

### ХЯНАЛТЫН АЖИЛ

I.\* Переведите письменно с монгольского языка на русский:

1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь манай улсын дотоод бүрэн эрхийн асуудал, гадаадын зээл тусламжийн хөрөнгийг үр бүтээлтэй ашигтай хэрэглэхийн үндэс суурь бүрэлдэх эх сурвалж болох нь зайлшгүй.

2. Монголчуудын саналыг тун бага тусгасан 1915 оны Хятад Орос Монголын гурван улсын гэрээний дагуу Монголын тусгаар тогтносон бус автономит улс гэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэхүү бүрхэг ойлголт нь 1946 он хүртэл маргаантай байдлын эх үүсвэр болжээ.

3. Чингисийн засаг-хууль түүний байгуулсан эзэнт гүрний амьдралд их үүрэг гүйцэтгэж монголчуудын төдийгүй түүнд эзлэгдсэн ард түмний амьдралд гол хууль нь болж байжээ.

4. Эрх үүрэг хоёр бол манай орны амьдрал эдийн засгийн харилцаа гэж болно. Эрх үүрэг хоёр нь арга билэг хоёр мэт ажээ. Нэг нь нөгөөгүйгээр утгагүй мэт. Үүрэг бол амьдралын зорилго утга учир байхад эрх нь хүний аз жаргалын баталгаа гэж болно.

5. Эрдэмтэд «Нууц товчооны» зохиогчийн нэрийг тогтоох гэж янз бүрийн санал таамнал дэвшүүлж байна.

6. «Нууц товчоо» бичигдснээс хойш зуугаад жилийн дараа Европд италийн их яруу найрагч Данте «Тэнгэрлэг туульсаа» туурвижээ.

7. Хэрвээ «Нууц товчооны» монгол эх олдвол бас нэг оньсог тайлагдаж Чингис богдын онгоныг тодруулснаас дутуугүй нээлт болно.

8. «Нууц товчоо» монгол үндэсний оюун ухаан авьяас билгийн эрчим хүчнийг өөртөө агуулсан болохоор сүсэглэн уншсан хүнд анагаах рашаан эдгээх эм ч болох юм. Зөвлөлтийн яруу найрагч А.Вознесенскийн бичсэнийг санаж байна. Бие нь чилээрхээд эмч домч нарт үзүүлээд ч сайжирсангүй. Тэгээд оросын эртний утга зохиол судлагч академич Д. Лихачеваас зөвлөлгөө авахад нь «Игорийн цэрэглэсэн туужийг» хэд дахин унших, тэгвэл бие чинь илааршина гэж хэлжээ. Ингээд А. Вознесенский оросын тэр алдарт зохиолыг шимтэй уншаад бие нь сайжирсан гэнэ. (Ц. Хасбаатар).

9. Чингис Жамуха хоёрын харилцааны асуудлыг «Нууц товчооны» бас нэгэн оньсог гэж хэлж болно. Жамуха Чингисээс урвасан дүр үзүүлж чухамдаа Тэмүүжинтэй анх тохиролцсон андгай тангарагтаа чин үнэнч байж эзэн хаандаа гуйвалтгүй зүтгэсээр гүн эмгэнэлтэйгээр цаазлуулсан гэдэг маш сонирхолтой таамаглал бий.

## II. Переведите предложения с русского языка на монгольский:

1. «Сокровенное сказание» — это энциклопедия жизни монгольского народа.
2. Поистине удивительна судьба «Сокровенного сказания».
3. Существует много тайн, связанных с судьбой «Сокровенного сказания».

4. «Сокровенное сказание монголов» осталось в записи китайскими буквами на монгольском языке.
5. Древнемонгольская легенда о Чингис-хане.
6. «Сокровенное сказание» написал человек, сам принимавший участие в исторических событиях, имевших место в Монголии.
7. В «Сокровенном сказании» повествуется о том, как Чингис-хан объединил все монгольские племена и создал единое монгольское государство.
8. Борьба Чингис-хана за объединение монгольских племен и создание единого монгольского государства.
9. В «Сокровенном сказании» средствами художественной литературы описывается подлинная история борьбы Чингис-хана в более чем тридцати особых рассказах.
10. Один из таких особых сюжетов в начале «Сокровенного сказания» — рассказ о Дува-сохоре и Добу-мэргэне.
11. На лбу Дува-сохора есть единственный глаз. Он видит земли на расстоянии трех кочевий.
12. «Сокровенное сказание» — не только историческое сочинение, но и памятник художественной литературы.

## Үг хэллэг

**хөлгөн судар** первая, главная книга;

**хөлөг скакун**

**сүрлэг оргил** величественная вершина

**нэвтэрхий толь** энциклопедия

**хувь заяа, хувь тавилан** судьба

**Оросын шашны төлөөлөгчдийн газрын бүтээл** «Труды членов Российской духовной миссии в Пекине» (Т. 4, СПб., 1866)

**тэмдэглэсэнчлэн** как отмечал...

**он дараалан** в хронологической последовательности

**хүнд өгөөгүй, эрд өгөөгүй** не просватана

**ганц түүхийн зохиол** төдийгүй не только историческое сочинение

**данслах арга** строгое (по списку) изложение, сухое перечисление событий

**дүрслэх** изображать;

**дүрслэх урлаг** изобразительное искусство

**дүр** герой, персонаж;

**дүрс** образ

ач холбогдолтой иметь значение  
соёлыг хөгжүүлэх дэлхий дахины арван жил десятилетие развития культуры  
монголч эрдэмтэд монголо-веды  
их хуралд оролцогчид участники конгресса  
хосгүй бүтээл уникальное произведение  
олон улсын хэмжээнд на международном уровне  
санал нэгтэй дэмжих единоголосно поддержать  
хил давах перейти границу  
хөөх гнаться;  
хойноос следом;  
буудах стрелять  
түрэн орох ворваться  
шархдуулах ранить  
хилэгнэх гневаться  
зөрчил конфликт  
хурцдах обостриться

яаралтай срочный;  
эвлэрэх компромисс  
төлбөр плата  
алдах терять  
алах убивать  
амлах обещать  
олох находить  
олдох находиться  
биелүүлэх выполнять  
бие тело  
хашгирах кричать  
хөтлөх вести  
уурлах сердиться.  
Хаачих гэж байна? Куда направляетесь?  
Тэгэлгүй яах вэ? Конечно, а как же иначе?  
салхинд гарах выйти на прогулку, проветриться  
эргэн тойрон вокруг  
хир эртний насколько древний?  
эн зэрэгцүүлэх сравнить

## МОНГОЛЬСКАЯ КНИГА. МОНГОЛ НОМ

Слово **ном**, вероятно, восходит к древнегреческому «**номос**» — закон. В монгольском языке **ном** также означает еще и учение. Старинные книги всегда начинались с формулы: **бурхан, багш, ном гурван эрдэни-дур моргомуй**. Поклонимся трем драгоценностям: Будде, учителю (здалама) и учению.



Письменная литературная традиция в Монголии восходит к первому дошедшему до нас памятнику об истории рода чингизидов «Нууц

товчоо» (1240 г.). Книга в Монголии принимала самые разнообразные формы: книги, вышитые на ткани, ксилографы, книги на пальмовых листьях, книги, написанные с использованием драгоценных камней («девять драгоценностей»). Важные события своей истории в древности кочевники фиксировали на камне. Самая ранняя «камнеписная книга» монголов *Чингисов камень* относится к 1225 г.

---

Ответы на загадки:

1. Дождь
2. Спички

## БУДДИЗМ В МОНГОЛИИ

### ГРАММАТИКА

1. **Выражение** — что касается, в качестве, передается при помощи сочетания *-ын хувьд*:

Улс төрийн хувьд зайлшгүй шийдвэрлэвэл зохих тийм тулгамдсан асуудал манай хоёр орны хувьд байхгүй юм.

— В политическом смысле у наших стран нет таких актуальных проблем, которые требуют безотлагательного решения;

2. *болгон* — в качестве.

3. **Сослагательное наклонение** в монгольском языке образуется при помощи причастия прошедшего времени в середине предложения с частицей *бол* и причастия будущего времени с частицей *сан*. Например:

Дэлгүүрт ийм ном байсан бол би авах сан.

— Если бы в магазине была такая книга, я бы купил.

Бат хичээлээ сайн давтсан бол муу дүн авахгүйсэн.

— Если бы Бат хорошо повторил уроки, он не получил бы двойку.

4. **Послелог тутам** — употребляется с причастием будущего времени. Переводится: *чем... тем*, например:

Тэр айлд ойртох тутам улам олон мал харагдлаа.

— Чем ближе к айлу, тем больше было видно скота.



**5. Уменьшительная частица -хан.** Употребляется с прилагательными и числительными. Например:

<b>сайн</b> — <b>сайхан</b>	прекрасный
<b>хөөрхий</b> — <b>хөөрхөн</b>	хорошенький
<b>гурав</b> — <b>гуравхан</b>	всего три

## **6. Числительные.**

а) собирательные: -уул, -үүл:

**Хэдүүл вэ? Тавуул** впятером, **дөрвүүл** вчетвером, **хоёул** вдвоем;

б) кратные: -аад (чаще употребляется с десятками):

**арваад** около десяти, в десятых числах;

в) слитное: -аар:

**гурав** — **гурваар** по три.

## **ПРАКТИЧЕСКАЯ ГРАММАТИКА**

**Дасгал 1.\*** Переведите с монгольского языка на русский, уделяя внимание сослагательному наклонению:

1. Залуучуудын хуралд ирсэн төлөөлөгчид «Улаанбаатар» зочид буудалд буусан гэнэ. Завтайсан бол очиж уулзах юмсан. За, алга. 2. Энэ сонинд их сонирхолтой өгүүлэл байгаа бололтой. Хэрэв Солонгос хэл мэддэгсэн бол унших юмсан. 3. Мөнгөтэй яваасан бол талх аваад харих юмсан. Мөнгөө гэртээ өрхичихжээ. 4. Тэр хүн зохиолч юм бол уулзаж шүлгий нь уншуулах юмсан. Зөвшөөрөх бол уу? 5. Хэрэв би маргааш явахсан бол чамтай дахиж уулзахсан. Гэтэл би өнөөдөр явна шүү дээ. 6. Багш ирсэн бол энэ үгийг асуух юмсан. Би ер ойлгохгүй байна.

**Дасгал 2.** Дополните предложения, восстановив всю фразу по-монгольски:

1. Если бы я был богат ... . 2. Если бы сейчас было лето ... .  
3. Если бы я поехал в Монголию ... . 4. Если бы я знал японский язык ... . 5. Если бы у меня было много свободного време-

ни ... . 6. Если бы я был молодым ... . 7. Если бы у меня была машина ... .

**Дасгал 3.** Придумайте 5 предложений с послелогом *-х тутам* по образцу:

1. Цас орох тутам тэнгэр хүйтэрч байна.
2. Өдөр хоног өнгөрөх тутам миний найз шинэ шинэ юм сурч байна.

**Дасгал 4.** Вставьте вместо точек подходящий послелог, указывающий направление действия — *дээш(ээ)*, *доош* и т. д.:

1. Дотор байсан хүмүүс ... гарч, гадаа байсан хүмүүс ... оров.
2. Та хаашаа явж байна? Би ... явж байна 4-р давхарт гаръя.
3. Та наашаа битгий хар ... хар!
4. Салхи хойноос байхад үүл хаашаа нүүх вэ? Салхи хойноос байхад үүл ... нүүнэ.
5. Нисэж яваа онгоцноос ... хараад хот, тосгон, уул, даваа, гол, горхи цөм сонин сайхан харагддаг.

**Дасгал 5.**

Расскажите, что вы знаете о буддизме.

Почему буддизм в Монголии называют «желтой» верой?

Что означает желтый цвет в Китае?

**Дасгал 6.** Переведите с русского языка на монгольский:

1. Идет дождь.
2. Поезд прибыл вовремя.
3. Дни уходят (проходят).
4. Время идет быстро.
5. Работа идет хорошо.
6. Ученики идут в школу.
7. Мой сын научился ходить.
8. По этой дороге никто не ходит.
9. В ходе переговоров подписали протокол.
10. Стороны пришли к соглашению.
11. Иди быстрее!
12. Иди сюда!
13. Дорогу осилит идущий.

**Дасгал 7.\*** Переведите с монгольского языка на русский, обратите внимание на разные значения глагола *явах*:

1. Тэр өдрөөс эхлэн өдөр бүр ээж хониндоо явдаг болсон.
2. Сургуульд явдаг том хүү нь унтаж байв.
3. Цэрэгт явахынхаа өмнө би хонь хариулж байлаа.
4. Миний өмнө явсан хоёр хүүхэн

өмссөн хувцасныхаа өнгө чанарыг ярилцав. 5. Тэр бүхнийг би үзэн ядаж ч явсангүй биширч шүтэж ч байсангүй. 6. Явсан нохой яс зуудаг. 7. Амьд явсан хүн алтан аягнаас ус ууна. 8. Амьд явахын учир. 9. Ахынхаа бичсэн захиаг би уншаад явав. 10. Сайн яваад ирэв үү?

**Дасгал 8.** Продолжите предложения:

1. Өдөр хоног өнгөрөх тутам ... . 2. Би ерөнхийлөгч байсан бол ... . 3. Хэрвээ би машинтай байсан бол ... . 4. Хичээл тарсны дараа ... . 5. Бие муутай болсноос ... . 6. Монголын нэгдсэн улс байгуулснаар ... . 7. Шинэ Үндсэн хуулийг баталснаас хойш ... . 8. Миний бодлоор энэ маргаан ... . 9. Амьдралын нөхцөл муу байвал ... . 10. Монгол ном унших тутам ... . 11. Сонинд бичснийг уншаад ... . 12. Тэр залуу Улаанбаатарт суралцаж байхад ... . 13. Миний зогсож байгаа энэ газарт ... . 14. Шинэ жилийн баярыг тохиолдуулан ... . 15. Д. Нацагдорж зөвхөн яруу найрагч төдийгүй ... . 16. Б. Я. Владимирцов бол монгол ардын аман зохиол, уран зохиолын судлалыг бие даасан шинжлэх ухаан болгон хөгжүүлэхэд ... . 17. А. Позднеев Монголд удаа дараа ирж ... . 18. «Нууц товчоог» судалж орчуулахад С.А.Козин жинтэй хувь нэмэр ... . 19. Чингис-хаан нас барснаас хойш ... . 20. «Нууц товчоо» шиг гайхамшигт зохиол гараагүй боловч түүх бичлэг ... .

### **Монголын шарын шашин\***

Монголын шарын шашин эртний Энэтхэгийн гүн ухаан бурхны шашны нөлөөгөөр ертөнцийг үзэх үзэл нь бүрэлдэн боловсорсон Зонхов Лувсандагвын (1357—1419) номлол дээр үндэслэсэн шарын шашны ном сургаал ёс дэглэмийг удирдлага болгосон юм.

...Халхын зүүн гарын ноён Автай (1554—1588) түмэн засагт хааны даалгавраар Хөх хотод очиж Далай лам Содномжамцтай учран өөрөө шарын шашинд орж Буддын шашны нэг хувилбар болох гелегваагийг (гэлукпа) буюу «шар малгайтны» шашныг дэлгэрүүлэхээр тохирчээ.

Түүнээс хойш 1588 онд Автай сайн хаан Монголын эртний нийслэл Харахорин хотын туурин дээр халхын анхны шарын шашны төв Эрдэнэзууг байгуулжээ. Мөн Хөх морин жил (1654) Хэнтий уулын өвөрт шарын шашныг бадруулах ривогэжай Гандан шаддублин хэмээх номын их хүрээ байгуулснаар шар нохой жил (1778) нүүлгэж шашныг бадруулагч хийдийн ойр Туулын голын хойт эрэгт авчирсан нь одоогийн Улаанбаатар хотын суурь болсон билээ.

Хувьсгалын өмнөх Монгол оронд 115 мянган лам нарыг хамарсан (эдгээрийн 20 гаруй мянган нь сургуулийн насны хүүхдүүд) 750 гаруй сүм хийд байсан гэдэг.

Монголоос бясалгал үйлдэхээр бурхны орон гэж алдаршсан Цаст Төвдийн оронд очиж байсан боловч тэдний маш цөөн нь ясаа нутагтаа тавихаар эргэж ирдэг байсан гэлцдэг. Шаддын хийдийг дацантай дацангүй хийдүүдэд мөргөл үйлдэх, хурал хурах, шашны анхан шатны боловсрол олгох үүрэгтэй. Ийм бага жижиг хийдүүд гол төлөв хөдөө орон нутагт байгуулагдаж байжээ. Харин дацантай хийд нь хэмжээгээр том, олон ламтай хийд байжээ.

Монголд түгээмэл нь цанид буюу чойрын дацан байв. Цанид гэдэг нь мэргэн ухааны мөн чанар гэсэн утгатай үг бөгөөд төвдөөр чойр гэж дууддаг. Энд буддагийн гүн ухаан ба бурхан багшийн намтар, уран зохиол, сэтгэл зүй, учир шалтгааны ухааныг судалдаг. Цанидын дацан нь 13 анги буюу зиндаантай. Зиндаан нь мэдлэгийн түвшингөөр ялгаатай.

## Үг хэллэг

Халхын зүүн гарын ноён — князь из Джунгарии	хувилбар — разновидность, вариант
гүн ухаан — философия	бясалгал үйлдэх — заниматься медитацией, йогой
ертөнцийг үзэх үзэл — мировоззрение	яс тавих — умереть, букв. сложить кости
бүрэлдэн боловсорсон — сформировалось	мөн чанар — сущность
номлол — проповедь, учение	учир шалтгааны ухаан — логика


## МОНАСТЫРЬ «ПОКОЯ И РАДОСТИ»

Монастырь Амарбаясгалант, задуманный как усыпальница Ундургэгэна, был построен в 1727—1736 годах по приказу маньчжурского императора Канси. История гласит, что первый монгольский богдо Ундур-гэгэн Занабазар умер в 1723 году во время визита к маньчжурскому императору. Возможно, чтобы снять кривотолки об истинной причине его смерти, а по официальной версии — для увековечения его памяти, император издал указ о возведении храма в честь Ундур-гэгэна и выделил на это деньги и людей. Монастырь решено было построить в северной части Монголии, среди красивых гор, в живописной долине.

Ансамбль построен строго по канонам, установленным для строительства монастырских и дворцовых сооружений. Размеры, форма и характер декоративного убранства храмов обусловлены и подчинены единому архитектурному замыслу, а их обилие и разнообразие не нарушают архитектурной целостности ансамбля.

С каждой террасы перед вами открывается перспектива новых храмов, а оглянувшись, вы долго не можете оторвать взгляда от уже пройденного пути. Переходя из храма в храм и поднимаясь по террасам со двора на двор, не перестаешь поражаться многоликости и разнообразию, неожиданным ракурсам, в которых предстает то одно, то другое сооружение ансамбля — от интимных уголков с постройками типа беседок до захватывающего дух величественного столонного главного храма.

Главный храм — Чогчин дугана — поражает не только своими размерами и архитектурными решениями, но и инженерными сооружениями. Уникальна система стока дождевых вод, которые с крыши текли по полым колоннам через все здания и выходили наружу по обложенным камнем стокам.



## Дасгалууд

**Дасгал 9.** Переведите вопросы с русского языка на монгольский, найдите в тексте ответы на них:

1. Кто основал школу «желтошапочников» в ламаизме? 2. Как формировалось мировоззрение Зонхавы? 3. Кто и в каком веке начал распространение буддизма в Монголии? 4. В каком году Абатай-хан построил первый буддийский монастырь? 5. Как назывался первый буддийский монастырь? 6. Когда был построен Гандан? 7. Сколько было монастырей в Монголии до революции? 8. Зачем верующие и ламы «ходили» в Тибет? 9. Какое различие существует между большими и маленькими монастырями? 10. Что такое дацан? Какие дацаны, в основном, строились? 11. Сколько степеней включает в себя цанид?

**Дасгал 10.\*** Запомните выражения:

ном сургаал, номлол, засагт хаан, хөх морин жил, шар нохой жил, шашныг бадруулах, шашныг дэлгэрүүлэх, бясалгал үйлдэх, ясаа тавих, дацантай хийд, мөргөл үйлдэх, хурал хурах, шашны анхан шатны боловсрол олгох, гол төлөв, мэргэн ухааны мөн чанар, цанид, чойр, Бурхан багшийн намтар, сэтгэл зүй, учир шалтгааны ухаан, зиндаан, мэдлэгийн түвшин.

**Дасгал 11.** Перескажите текст по-русски. Составьте план рассказа по-монгольски.

**Дасгал 12.** Переведите с русского языка на монгольский письменно:

1. Первый буддийский монастырь в Монголии был основан в 1558 году. 2. Буддизм является одной из самых древних и влиятельных мировых религий. 3. Распространение буддийской культуры из Индии в Тибет, Монголию, Китай, Японию, страны Южной и Юго-Восточной Азии способствовало появлению в национальных культурах этих стран новых элементов и в то же время обогатило саму буддийскую культуру разнообразными традициями. 4. По закону кармы (үйл) все живые существа сансары должны в конце концов перейти в нирвану. 5. В монгольском историческом труде «Хрустальное зеркало», написанном

Да-ламой Жамбалдоржем из Внутренней Монголии в 1835 году, изложены биографии индийских и тибетских проповедников буддизма. 6. В период интенсивной переводческой деятельности в XVII—XVIII вв. монголы выработали принципы перевода с санскрита, тибетского, китайского языков религиозно-философской и научной литературы. 7. В ранний период распространения буддизма в Индии начали складываться джатаки — легенды и предания о прошлых перерождениях Будды. 8. Джатаки стали главным средством пропаганды буддизма среди широких слоев населения. 9. Благодаря широкому распространению буддизма в Монголии, в монастырях были созданы так называемые печатные дворы, или типографии, издававшие огромное количество кириллографов на самые разные темы.

**Дасгал 13.\*** Переведите с монгольского языка на русский:

1. Монголын төр шашны түүхийг судлахдаа Жавзандамба хутагтуудын намтар түүхээс ангид үзэх нь учир дутагдалтай болох билээ. Жавзандамба Хутагтыг монголчууд бас «Өндөр гэгээн» буюу «Богд гэгээн» гэж өргөмжилдөг байжээ. Тэгвэл XVII—XVIII зууны монголын нийгэм, улс төр, шашны үйл ажиллагаанд ихээхэн нөлөөтэй оролцож ялангуяа урлаг, соёл, хэл бичигт өөрийн гэх өвөрмөц гайхамшигтай давтагдашгүй бүтээлээ үлдээж иргэний болон шашны зан үйлд зохих хэмжээний оорчлөлт оруулсан нэгэн суутан бол Өндөр гэгээн хэмээн олноо өргөгдсөн Занабазар билээ.

2. Тэрээр арван хоёр настайдаа Сарын голд «бүхнийг номхотгогч» хэмээх баруун хүрээг гал гахай (1647) жилд анхлан байгуулжээ. (Одоогийн Өвөрхангай, Харахорин сумын нутагт) Өндөр гэгээн Занабазарын байгуулсан Баруун хүрээ бол Халхад анх түрүүний шарын шашны сүм хийд болой.

3. 1651 онд тавиад Тангад болон энэ хэмжээний уран дархчуудын хамт Халхад ирж одоогийн Улаанбаатар хотын газарт Их хүрээг байгуулан шарын шашны ном хурлын гол төв болгов. Энд л (1675 оны орчим) гайхамшигт урлаг Очирдарь, язгуурын таван бурхан, Аюуш, Намсарай, Дарь эх зэрэг бүтээлээ урласан билээ.

4. Энэ үед Халх, Ойрдын тэмцэл ширүүсч 1686 онд Хүрэн Билчирт Өндөр гэгээн Халхыг төлөөлөн оролцсон байна. Удалгүй Халхад Галдан бошигтын цэрэг түрэн орж ирсэн тул халхчууд нэгэнт эсэргүүцсэн тэмцэх чадалгүй болж олон хүн, ван, гүн нар хуран цугларч орос нанхиадын алийг дагавал дээр вэ? гэвэл Жавзандамба хутагт «Хойд зүгийн орос хэмээх шар хятадын хааны төр шиг амгалан их улс боловч шашин эс дэлгэрсэн бас хувцасны зах нь буруу тул үл боломуй... хэмээн айлдав.

5. «Өөрөө төрсөн үзэгдэл» хэмээх соёмбо үгсийг зохиосон хэлний их мэргэжилтэн, уран барималч, төрийн аугаа их зүтгэлтэн анхдухаар Богд гэгээн Занабазар 1723 онд 89 нас сүүдэр жанч хальжээ.

**Дасгал 14.** Расскажите коротко по-русски о той обстановке, которая сложилась в Монголии в конце XVII века. Кратко сформулируйте ответы на следующие вопросы:

1. Какую роль буддизм сыграл в истории монгольского общества? 2. С какими историческими событиями совпал процесс распространения буддизма? 3. Кто был первым духовным правителем Монголии? 4. Назовите основные вехи биографии Занабазара. 5. Какие главные его деяния вошли в историю отечества? 6. Как в современной Монголии относятся к его духовному наследию? 7. Какое образование получил Занабазар? 8. В чем главная заслуга «Высокого святого»? Как вы думаете, в чем больше преуспел Занабазар — в развитии буддийского искусства или в решении политических задач? 9. Выразите свою точку зрения на исход событий накануне установления господства Маньчжурской династии в Монголии. Согласны ли вы с решением Занабазара?

**Дасгал 15.** Придумайте 10 вопросов, используя данные словосочетания:

монголчуудын оюуны соёл, мянгаад жилийн дотор хэрэглэсэн арваад бичиг үсэг, нүүдлийн аж ахуй, өнгөрсөн, одоо, ирээдүйн нэгдэл, эртний монголын нүүдэлч ард түмэн, найман тахил, таван махбод, гурван эрдэнэ, дөрвөн зүг, номын сургаал, номлол.



**Дасгал 16.\*** Переведите устно вводные слова и начальные фразы высказываний:

эндээс үзэхэд, эрт дээр үеэс эхлэн, эрдэмтдийн тэмдэглэснээр, тэрээр, энэ үед, тэгвэл, тэгээд, монголын төр шашны түүхийг судлахад, өөрөөр хэлэхэд, түүнээс гадна, юуны өмнө, түүнээс хойш, хувьсгалын өмнөх Монгол орон, бурхны орон гэж алдаршсан, нүүдэлчдийн орны хувьд, Их хүрээ байгуулснаар, яагаад гэвэл, учир нь, ийм учраас, миний бодоход, миний бодлоор, жишээ нь, тухайлбал, ядахдаа, энэ үеийн нийгмийн байдал бол...

**Дасгал 17.\*** Запомните некоторые буддийские термины:

үйлийн үр (карма или плоды деяний), бодисат (бодисатва), цанид, хүрд (молитвенное колесо), хийд (монастырь), гурван эрдэнэ — ном, багш, бурхан; маань (молитва), Ганжуур, Данжуур, модон бар, Арьявал бурхан (санскр. Авалокитешвара), Очирвань (Базарвань), хувилгаан, хутагт, шар малгайтан (Гэлукпа), орхимжи, санваартан, шавь, хамба-лам (настоятель монастыря), эрих (четки).

## ЯРИАНУУД\*

- Сайн байна уу? «Алтай» зочид буудал хүрэхэд аль буудлаас суух вэ?
- Багшийн дээд сургуулиас ч сууна.
- Ямар хаягтай автобусанд суух вэ?
- «12-р хороолол — Телевиз» гэсэн хаягтай автобусанд сууна.
- Тэгээд хаана буух вэ?
- Эцсийн буудалд нь бууна.

\* \* \*

- Таксийн буудал хаана байна?
- «Туул» рестораны тэнд бий.
- «Туул» ресторан хүрэх замыг зааж өгөхгүй юу?
- Чигээрээ явж байтал чинь нэг хүнсний дэлгүүр дайралдана. Тэндээс урагшаагаа эргээд чигээрээ яв. Олохгүй бол хүнээс асуугаарай.

\* \* \*

- Доржийнх хаа байдаг юм бэ? Чи мэдэх үү?
- Мэднэ. Чи Гандан хийдэд очиж үзсэн үү?
- Тэгвэл Гандангийн баруун талд нэг усан сан харагдаж байгаа. Тэр усан сангийн урд талд хойшоогоо харсан 15 тоот хүрэн хаалгатай хашаа. Тэр Доржийнх.

\* \* \*

- Би өчигдөр хичээл дуусангуут л дуурь бүжгийн театр луу гүйлээ.
- Яах гэж?
- Билет авах гэж. Тэнд нэг сайхан дуурь гарч байгаа юм. Манай ангийнхан бүгдээрээ үзсэн. Би л үзээгүй байна.
- Тэгээд билет авав уу?
- Авсан. Харин нөгөөдрийн билет авлаа. Өнөөдрийнхийг чадсангүй. Билет нь бас л дуусчихсан байна.
- Тэгвэл хоёулаа үдэшлэгт очъё.
- Хаана ямар үдэшлэгтэй юм бэ?
- Сургууль дээр. Сургуулийн 40 жилийн ойд зориулсан үдэшлэг болно шүү дээ!
- Үдэшлэгт очоод би дуулж ч чадахгүй, бүжиглэж ч чадахгүй шүү дээ! Кино л гарвал үзмээр байна.
- Кино ч гарна. Концерт ч тоглоно гэсэн.

\* \* \*

- Та энэ долоо хоногт ямар ямар ном уншив?
- (Би энэ долоо хоногт) Д.Нацагдоржийн зохиолоос хэдэн өгүүллэг уншлаа.
- Танд аль нь сайхан санагдав?
- Бүгдээрээ л сайхан зохиол юм. «Хуучин хүү» гэдэг өгүүллэг нь надад их аятайхан санагдлаа. Бас «үзэгдээгүй юм» гэдэг зохиол нь ч сонин юм. Та ямар ном уншив?
- М.Горькийн зохиол «Эх» гэдэг романыг уншлаа. Бас монголын зохиолчдын хэдэн шүлэг найраглал уншсан.
- Та «Эх» романыг оросоор уншив уу, монголоор уншив уу?
- Монголоор уншлаа. Их сайхан орчуулсан байна.

\* \* \*

- Өнөөдөр дуурь бүжгийн театрт юутай вэ?
- (Өнөөдөр) «Учиртай гурван толгой» дуурь гарна. Чи үзсэн үү?

- үзсэн. Их сайхан шүү.
- Гол дүрд нь хэн хэн тоглож байна?
- Юндэнд гавьяат жүжигчин Хайдав, Нансалмаад жүжигчин Цэвэлсүрэн нар тоглож байна.
- Хайдав гуай сайхан дуулж байна уу?
- Их сайхан дуулж байна.

\* \* \*

- Чи хаа очоод (хаачаад) ирэв?
- (Би) Баяр гуайнд очиж хүүгийн нь номыг өгөөд ирлээ.
- Баяр гуай гэртээ байна уу?
- Байна. Баяр гуайн эхнэр Ханд гуай ч гэртээ байна. Харин хүү нь л алга.
- Чи тэгээд номы нь яав?
- Баяр гуайд л өгчихлөө.

\* \* \*

- «Тэмцэл» гэдэг дуурийн билет байна уу?
- Өнөөдрийнх дууссан, маргаашийнх байна.
- Би хоёр билет авъя. Сайхан суудал өгөөрэй.
- Та араар суудал авах уу, урдуур суудал авах уу?
- Урдуур авъя. 5 дугаар эгнээнд суудал байна уу?
- Алга. Дууссан. 6 дугаар эгнээнд голын суудал байна. Авах уу?
- Авъя. Нэг билет ямар үнэтэй вэ?
- (Нэг билет) 6 төгрөг.

**Дасгал 18.** Переведите с русского языка на монгольский:

- Как вы проведете свой выходной день? Может быть, пойдете в кино?
- Лучше остаться дома и посмотреть по телевизору спортивную передачу.
- Я очень люблю смотреть по телевизору хоккей, хотя сам в хоккей не играю.
- А вас интересует спорт?
- Да, я люблю борьбу, кроме того, каждый выходной день езжу кататься на лыжах.
- А моя семья любит кататься на коньках, особенно младший сын. Дочь ездит во дворец спорта и занимается гимнастикой.

**Дасгал 19.\*** Переведите на слух причастные обороты:

Дорноговь аймагт эртний бичиг соёлын дурсгалыг хайрлан хамгаалж хадгалж үлдсэн хүн олон... Монгол газар болсон олон анх... Гадаадынханд нууц дамжуулсан хэргээр... А. С. Козины монгол уран зохиолын судлалд оруулсан хувь нэмэр... Монголын уран зохиолын түүхнийг судлах хүн... «Алтан дэвтэр» гэдэг түүхийн зохиол...

**Дасгал 20.** Переведите с монгольского языка газетные объявления:

Худалдана: Өмнөд Солонгосын шинэ хөргөгч үнэ тохиролцож... Булангийн зөөлөн диван үнэ тохиролцон...

Ажил түнш хайж байна.

Байр яаралтай худалдаж авна. Валют болон төгрөгөөр.

Эрэгтэй эмэгтэй хүний гутал засварлах үйлчилгээ нээгдэн ажиллаж байна. Гутлын бүх төрлийн үйлчилгээ хийж байна. Өргөнөөр үйлчлүүлнэ үү?

**Дасгал 21.\*** Переведите с монгольского языка на русский, обратите внимание на разные значения глагола *гэх*:

Үүнийг юу гэдэг? Юу гэсэн үг вэ? Юу гэнэ? Хүн гэдэг амьтан. Дипломат гэдэг хэцүү ажил. Монгол хэл сурна гэдэг амаргүй ажил. Бид гэсэн олуулаа... Найз маргааш ирнэ гэсэн. Өвөл хүйтэн болно гэнэ. Энэ кино үзэх гэсэн. Би ирнэ гээгүй. Ирнэ гээд ирээгүй. Багш унш гэж байна. Ээж талх аваад ир гэж байна. Уулзана гэсэн чинь яалаа? Тэр хүлээнэ гэв үү?

## ХЯНАЛТЫН АЖИЛ

**I.** Переведите с монгольского языка на русский:

1. Манай аав хотод ирмэгц чи түүнтэй уулзаарай..
2. Энд л Их Хүрээ байгуулагдсан юм.
3. Би орой ч сонин уншдаг.
4. Орос хэл би ч ах ч мэддэг.
5. Манай ах англи хэл ч мэднэ.
6. Хэрэв захиа ирэх юм бол би чамд хэлнэ.
7. Цэрэгт явахынхаа өмнө би хонь хариулж байлаа.
8. Дорж жүжиг үзэхээр явах гэж байна.
9. Тэдний дотор сайхан охин сууж явааг үзэв.

10. Энэ үйлдвэр ашиглалтад орсноор тус улсын экспортын хэмжээ нэмэгдсэн билээ.
11. Шинэ Үндсэн хуулийг баталснаас хойш манай орон хөгжлийн шинэ шатанд ороод байна.
12. Нилээд тогшсны дараа үүдээ нээв.
13. Өдөр хоног өнгөрөх тутам...
14. Урт замаар явах гэдэг том судар уншихтай адил.
15. Зоосны нүхээр харахгүйн баталгаа бий юу?
16. Маргааш явахаасаа өмнө уулзна.
17. Бие муутай болсноос ажилдаа орсонгүй.
18. Тэр залуу их сургуульд орохыг бодсон.
19. Энэ ажлыг хийхэд бэлэн байв.
20. Энэ анхаарвал зохих асуудал.
21. Манай хоёр орны харилцаа бэхжиж ирсэн юм.
22. Эрдэмтэд эл зохиолыг нилээд олон талаас нь судалсаар ирсэн боловч...
23. «Монголын нууц товчоог» дөрвөлжин бичгээр тэмдэглэснийг хятад галигт буулгасан байх гэдэг таамаглал дэвшүүлсэн байна.
24. Дөрвөлжин бичгийг гол төлөв төрийн албан хэрэгт хэрэглэж байсан боловч уран зохиолын холбогдолтой ном бичиг тэмдэглэж хэвлэж байсан мэдээ баримт бий.
25. Соёмбо үсгийг судлагчид улс төрийн болон шашин номын тусгай зорилгоор зохиосон гэж үздэг байна.
26. 1686 онд Занабазар соёмбо үсгийг зохисон нь үнэн бодитой баримт мөн боловч «огторгүйд үсэг харагдсан» гэх мэт нь чухам шашны үзэл санааг илэрхийлсэн домог үг юм.
27. Шинэ жилийн баярыг тохиолдуулан...

## II. Переведите письменно с русского языка на монгольский:

1. Рад приветствовать Вас в Москве. Ценим Ваш вклад в укрепление дружбы и всестороннего сотрудничества между Россией и Монголией.

Россия рассматривает Монголию в качестве своего естественного партнера и надежного соседа в Азии.

Глубокие исторические корни являются хорошей основой для развития дружбы и сотрудничества в новых условиях.

Поиски современной Монголией своего достойного места в мире, выбор многовекторной политики на международной

арене не должны привести к ослаблению десятилетиями складывавшихся многоплановых тесных связей между двумя нашими государствами.

2. В наших странах происходит переход от планово-директивной к рыночной экономике, то есть мы заняты схожими реформами. Убеждены в правильности избранного нами курса.
3. Это наша первая личная встреча, хотя мы достаточно хорошо знаем друг друга благодаря обмену посланиями. Нас объединяет общее стремление к развитию традиционных отношений добрососедства между нашими странами как важного элемента мира и стабильности в азиатском регионе.

Переговоры еще раз подтвердили, что равноправное взаимовыгодное сотрудничество между Россией и Монголией отвечает коренным интересам наших государств и народов, укреплению международного и регионального мира, стабильности и развитию. Это особенно важно в нынешней непростой международной обстановке. Считаю, что совместно с нашими азиатскими соседями мы можем и должны внести солидный вклад в обеспечение стабильности в Азии.

## ҮГ ХЭЛЛЭГ

эцсийн буудал    конечная оставка  
чигээрээ явах    идти прямо  
явж байтал    как пойдете... там будет...  
дайралдах    попасть навстречу  
тэгэхлээр    тем временем, как только, так случится  
эргэх    поворачивать  
урагшаа    вперед, на юг (обязательно только на юг)  
хойшоогоо    на север  
усан сан    водоем, бассейн  
хашаа    забор, хашан  
удирдлага болгон    руководствуясь  
тусламж болгон    в качестве помощи  
хэвийн болгох    нормализовать

хүчтэй болгох    усилить  
хүчингүй болгох    аннулировать  
бий болгох    дать начало, создать  
чимэг болгон    в качестве украшения  
үйлийн үр    карма или плоды деяний  
хүрд    молитвенное колесо  
хийд    монастырь  
маань    молитва  
Арьавал бурхан    санскр. Авалокитешвара  
Очирвань    Базарвань  
шар малгайтан    Гэлукпа  
хамба-лам    настоятель монастыря  
эрих    четки.

## ДОПОЛНИТЕЛЬНЫЕ ТЕКСТЫ

### Монголоор дайрах хийн хоолой алдаж болохгүй агшин

Олон улсын хооронд байгуулахаар зэхэж буй байгалийн хий дамжуулах хоолой Монголын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаар «Зууны мэдээ» сонин хоёр жилийн өмнө анх хөндөн бичиж байсан. Өнгөрсөн хугацаанд дээрх асуудал эцэслэн шийдэгдээгүй ч энэ талаар ОХУ, Хятад улсын хооронд гэрээ хэлэлцээр байгуулагдан сүүлийн үед хэвлэлээр нэн идэвхтэй мэдээлж буй нь энэ талын Монгол Улсын ашиг сонирхол тун бодит агуулгатай болохыг нотолж байна.

Ашиг сонирхлын тухайд эргэн өгүүлэхэд энэ нь тухайн орны газар зүйн байршил хэрэг өөрийн тодорхойлох үнэ цэнээс хамаарах нь мэдээж. Газрын зураг харвал Монгол Улс нь өрнөд, өмнөд, дорнод талаараа Хятадын, хойд, баруун хойд талаараа ОХУ, Дундад Азийн орнуудын, зүүн хойд талаараа Сибирь, Якут, Манжуурын гэх мэтчилэн газрын тос, байгалийн хийн томоохон сав газруудтай хиллэдэг. Энэ нь манай улс Сибирийн байгалийн асар их нөөц, зүүн хойд болон өмнөд Азийн эрэлт хэрэгцээ бүхий зах зээлийн дунд байрлаж байна гэсэн үг. Тиймээс ч ОХУ, Хятад, Япон, БНСУ, БНАСАУ, Туркмен, Казахстан зэрэг орон дээр өгүүлсэн Дундад Ази, Сибирь, зүүн хойд Ази гээд Евро Азийг холбосон байгалийн хий дамжуулах хоолойн нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг боловсруулахдаа үндсэн таван чиглэлийг авч үзсэний нэгэнд өмнө өгүүлсэн Монгол Улсын байршилтай шууд холбоотойгоор ОХУ-ын Эрхүүгээс (Ковыктинскийн ордоос эх авч) Монголыг дайруулан Хятадын чиглэлд тавих «зам»-ыг сонгон оруулсан бизээ.

Судалгаанаас үзэхэд Монголоор дайруулан хийн хоолой тавих хувилбар нь хол ойрын хувьд бусад чиглэлээс хоёр мянган км ойр эдийн засгийн хувьд хамгийн ойр дөт гэдгийг Орос, Хятадын тал аль аль нь анхаарч зөвшөөрч байсан. Бусад улс орнууд ч энэ чиглэлийг илүүтэй авч үзэн ач холбогдол өгч буй нь Монголоор дайрах ойр дөт замаас гадна нөөц ихтэй Ковыктинскийн (Эрхүүгийн) ордтой холбоотой юм. Тиймээс ч ОХУ-ын Засгийн газрын холбогдох байгууллагын төлөөлөгчид Хятадад

ТАБЛИЦЫ

**Собственно-глагольные формы**  
(финитные, употребляются только в роли сказуемого)

настояще-будущее время		прошедшее время			
повествоват. настоящ. момент		в	жээ	лаа	ж+байсан
-на	ж+байна				
явна	явж байна	явав	явжээ	явлаа	явж байсан
орно	орж байна	оров	оржээ	орлоо	орж байсан
ирнэ	ирж байна	ирэв	иржээ	ирлээ	ирж байсан
өгнө	өгч байна	өгөв	өгчээ	өглөө	өгч байсан
хийнэ	хийж байна	хийв	хийжээ	хийлээ	хийж байсан
болно	болж байна	болов	болжээ	боллоо	болж байсан

**Причастие**

ос-нова глаг.	наст. -буд.	однокр.	мно-гокр.	наст.	незаконч. прош.	прош.	возм.
	-ж	-гч	-даг	-аа	-аагүй	-сан	-маар
оч	очих	очигч	очдог	очоо	очоогүй	очсон	очмоор
сур	сурах	сурагч	сурдаг	сураа	сураагүй	сурсан	сурмаар
суу	суух	суугч	суудаг	суугаа	суугаагүй	суусан	суумаар
хэл	хэлэх	хэлэгч	хэлдэг	хэлээ	хэлээгүй	хэлсэн	хэлмээр
бай	байх	байгч	байдаг	байгаа	байгаагүй	байсан	баймаар
хий	хийх	хийгч	хийдэг	хийгээ	хийгээгүй	хийсэн	хиймээр
яа	яах	яагч	яадаг	яагаа	яагаагүй	яасан	яамаар
бол	болох	бологч	болдог	болоо	болоогүй	болсон	болмоор

**Склонение причастий**

имен.	род.	вин.	дат.	совм.	исх.	оруд.
ирсэн	ирсний	ирснийг	ирсэнд	ирсэнтэй	ирснээс	ирснээр
болох	болохын	болохыг	болоход	болохтой	болхоос	болхоор
байгаа	байгаагийн	байгааг	байгаад	байгаатай	байгаагаас	байгаагаар
гэдэг	гэдгийн	гэдгийг	гэдэгт	гэдэгтэй	гэдгээс	гэдгээр



## Склонение существительных

имен.	род.	вин.	дат.	совм.	исх.	оруд.
ах	ахын	ахыг	ахад	ахтай	ахаас	ахаар
ном	номын	номыг	номонд	номтой	номоос	номоор
гэр	гэрийн	гэрийг	гэрт	гэртэй	гэрээс	гэрээр
бичиг	бичгийн	бичгийг	бичигт	бичигтэй	бичгээс	бичгээр
цай	цайн(ы)	цайг	цайнд	цайтай	цайнаас	цайнаар
хоног	хоногийн	хоногийг	хоногт	хоногтой	хоногоос	хоногоор
өрөө	өрөөний	өрөөг	өрөөнд	өрөөтэй	өрөөнөөс	өрөөгөөр
бие	биеийн	биеийг	биенд	биетэй	биенээс	биеэр

## Вопросительные слова

ЮУ — юуны, юуг, юунд, юунаас, юутай, юугаар, юу руу

ХЭН — хэний, хэнийг, хэнд, хэнээс, хэнтэй, хэнээр, хэн рүү

ХЭД — хэдний, хэдийг, хэдэнд, хэдээс, хэдтэй, хэдээр

АЛЬ — алины, алинд, алинаар, алинаас

ЯМАР —

ХААНА — хаанаас, хаагуур

ХЭЗЭЭ — хэзээний, хэзээд

Яах — яаж, яагаад, яана, яасан, яаж байна, яах вэ?

## 1, 2, 3 лицо глаголов

основа	-я, -е, -ё	-аач	-аарай	л даа	-х уу?	-на уу?
яв-	явъя	яваач	яваарай	яв л даа	явах уу	явна уу
ярь-	ярья	яриаач	яриаарай	ярь л даа	ярих уу	ярина уу
суу-	сууя	суугаач	суугаарай	суу л даа	суух уу	сууна уу
ор-	орьё	орооч	ороорой	ор л доо	орох уу	орно уу

## II-III

основа	-уузай	-аасай	-гтун	-тугай	-г
март-	мартуузай	мартаасай	матагтун	марттугай	мартаг
бол-	болуузай	болоосой	бологтун	болтугай	болог

## Склонение местоимений и категория принадлежности

имен.	род.	вин.	дат.	исх.	совм.	оруд.	напр.
би	миний минь	намайг	надад	надаас	надтай	надаар	над руу
өөр(өө)	өөрийн	өөрийг	өөрсдөө	өөрөөс өөртөө	өөртэй		
чи	чиний	чамайг	чамд	чамаас	чамтай	чамаар	чам руу
чинь	чинийхээ	чамайгаа	чамдаа	чамаасаа	чамтайгаа	чамаараа	
та таны	таныг тань	танд(аа)	танаас(аа)	тангай(гаа)	танаар(аа)	тан руу(гаа)	
тэр	түүний(хээ) нь	түүнийг(ээ)	түүнд(ээ)	түүнээс(ээ)	түүнтэй(гээ)	түүгээр(ээ)	түүн руу
бид	бидний	биднийг	биднийг	бидэнд	биднээс	бидэнтэй	бидэн руу
мань	манай	манайд					
манайх	манайхны	манайхныг	манайханд	манайхнаас	манайхантай	манайхнаар	манайх руу
тэд	тэдний	тэднийг	тэдэнд	тэднээс	тэдэнтэй	тэднээр	тэдэн руу
энэ	үүний	үүнийг	үүнд	үүнээс	үүнтэй	үүгээр	үүн рүү
энд	эндээс						
тэнд	тэндээс						

## Числительные

хэдэн	нэг(эн)	хоёр	гурав(ан)	дөрөв(өн)	тав(ан)	зургаа(н)	долоо(н)	найм(ан)	ес(өн)	арав(ан)	хорь(ин)	гуч(ин)
нэгжээд	хошоод									арваад	хориод	гучаад
хэдүүл(ээ)	ганцаар(аа)	гурвуул(аа)	дөрвүүл(ээ)	тавуул	зургуул	долуул(аа)	наймуул(аа)	есүүл	арвуул	хориул		
хэддүгээр (хэдлэх)	нэгдүгээр (нэгдэх)	хоёрд(аа) (хоёрдахь)	гуравдугаар (гуравдахь)	дөрөвдүгээр (дөрөвдэх)	тавдугаар (тавдахь)	зургаадугаар (зургаадахь)	долоодугаар (долоодохь)	наймдугаар (наймдахь)	есдүгээр (есдэх)	аравдугаар (аравдахь)	хорьдугаар	
хэднээс	нэгнээс	хоёроос	гурваас	дөрвөөс	тавнаас	зургаанаас	долооноос	наймнаас	еснөөс	аравнаас	хориноос	
хэдтэй	нэгтэй	хоёртой	гуравтай	дөрөвтэй	тавтай	зургаатай	долоотой	наймтай	естэй	аравтай	хорьтой	

## Причастия с послелогоми

пад.		послелог	значение		после-лог	значение
имен.	-х	тутам тусам хуртэл хооронд турш	чем больше  до того, как когда, в то время, как	-сан	хойно дунд хооронд	после того, как, когда
род.	-хын	өмнө зэрэг төлөө хооронд улмаас дараа зуур	до того, как наряду с тем за, во имя в то время, как по мере того, как после того, как в то время, как	-сны	дараа дотор улмаас дээр	после того, как в то время, как из-за того, кроме того, что
дат.	-хад		когда, для, в	-санд		от того, что
вин.	-хыг		что (дополнение)	-сныг		из-за того, что  что (дополнение)
совм.	-хтай	хамг зэрэг зэрэгцээ адил	вместе с тем как, наряду с тем как также, как	-сантай  сатай	хамг зэрэг адил	вместе с тем, как также, как
оруд.	-хаар		для того, чтобы	-снаар барахгуй -снаар		не только, но и (үл барам) в результате того, что
исх.	-хаас	өмнө наана нааш болж болоод эхлээд	до того, как	-снаас	хойш нааш гадаа гадна	после того, как  с тех пор, как кроме того, что

пад	гэдэг	байгаа	болох
род.	гэдгийн	байгаагийн	болохын
вин.	гэдгийг	байгааг	болохыг
дат.	гэдэгт	байгаад(аа)	болоход
совм.	гэдэгтэй	байгаатай	болохтой
исх.	гэдгээс	байгаагаас	болохоос
ор.	гэдгээр	байгаагаар	болохоор

**Послелого  
(пространственная функция)**

хаана? где?	перевод с глаг. дв.	хаагуур? где?	хаанаас? откуда?	хаашаа? куда?	аль зүгийн? какой?	хаанахын? где нахал?
өмнө	юг, перед		өмнөөс		өмнөд	өмнөх
урд урьд		урдуур	урьдаас	урагшаа	урьд	урьдах
хойно	север	хойгуур	хойноос	хойш(оо)	хойд(хойг)	хойгохь
ар	сзади	араар	араас	ар тийш(ээ)	арын	
зүүн	восточный, левый		зүүнээс	зүүн тийш	зүүн	
баруун	западный, правый		баруунаас	баруун тийш	баруун	барууныхан
зүүн- өмнө	юго- восток		зүүн- өмнөөс	зүүн- урагш(аа)	зүүн-өмнөд	зүүн өмнөх
зүүн- хойно	северо- восток		зүүн- хойноос	зүүн- хойш(оо)	зүүн-хойд	
баруун- өмнө	юго- запад		баруун- өмнөөс	баруун- урагш(аа)	баруун- өмнөд	
баруун- хойно	северо- запад		баруун- хойноос	баруун- хойш(оо)	баруун- хойд	
өрнө	запад		өрнөдөөс		өрнөд	өрнөдийнх

дорно	восток		дорнодоос		дорнод	дорнодынх
дээр	верх, на, над	дээгүүр	дээрээс	дээш(ээ)	дээд	дээрх
дор (доор)	внизу, под	доогуур	доороос дороос	доош(оо)	доод	дорхи
дотор	средн, внутрн	дотуур	дотроос	дотогш(оо)	дотоод	доторхи
дунд	средннй	дундуур	дундаас		дундад	дундахь
гадна	снаружн, вне		гаднаас	гадагш(аа)		галдахь
гадаа		гадуур	гадаадаас		гадаад	гадаадын
наана	с этой сторонн	наагуур	наанаас	нааш(аа)	наад	наадах
цаана	с той сторонн	цаагуур	цаанаас	цааш(аа)	цаад цаашид	цаадахь
дэргэд	рядом около	дэргэдүүр	дэргэдээс			дэргэдэх
хажуу		хажуугаар	хажуугаас			хажуу дахь
энд	здесь	үүгээр	эндээс	ийш(ээ)		эндхийн
тэнд	там	түүгээр	тэндээс	тийш(ээ)		тэндхийн
алс хол	далеко		холоос			алсын, холын
ойр	близко		ойроос			ойрхи

Алс дорнод — Дальний Восток      Дорно дахины — Восток  
Ойрхи Дорнод — Ближний Восток      Дэлхий дахины — всемирный

## **РЕЧЕВЫЕ МОДЕЛИ ДЛЯ ВЕДЕНИЯ БЕСЕДЫ**

### **Начало беседы**

Я хотел бы начать с...	Эхлээд ... тухай (галаар) ярьж гэж бодож байна.
Вначале, во вступительном слове, во вступлении я хотел бы...	Оршиж хэлэхэд би ... гэсэн.
Вначале я хотел бы...	Эхлээд би ... гэсэн.
Прежде всего я хотел бы отметить...	Юуны өмнө би ... тэмдэглэх гэсэн.

### **Ход беседы**

#### **Проявление интереса**

Не могли бы Вы высказать свое мнение о...	Та ... асуудлаар юу бодож байгаагаа хэлэхгүй юу?
Можно попросить Вас высказать свое мнение по этому вопросу?	Энэ асуудлаархи Таны санал бодлыг яриулмаар байна.
Какова Ваша точка зрения по...	...Та юу гэж бодож байна?
Я хотел бы (у)знать...	Танаас асуух юм байна.
Я хотел бы спросить (задать вопрос)...	Надад асуулт байна.
Разрешите Вас спросить...	Танаас юм асууж болох уу?
Объясните, пожалуйста...	Тайлбарлаж өгөхгүй юу?



Как Вы расцениваете это высказывание (заявление, шаг)?

Та сая хэлсэн үгийг (мэдэгдлийг, алхмыг) юу гэж үзэж байна?

Как Вы считаете (полагаете)...? Та юу гэж үзэж байна?

Скажите, пожалуйста, это Ваше личное мнение или это официальная позиция Вашего правительства?

Энэ нь Таны өөрийн хувийн үзэх үзэл эс гэвэл Таны засгийн газрын албан ёсны байр суурь болж байна уу?

Ну, а каковы Ваши конкретные предложения по данному вопросу?

Тус асуудлаар тодорхой санал байна уу?

### Высказывание мнения

Я считаю, полагаю, думаю...

...гэж би бодож (үзэж, санаж) байна.

По-моему...

Миний бодлоор...

Я придерживаюсь того мнения...

Миний бодоход...

Миний үзэж байгаагаар...

Я хотел бы дополнить...

Нэмж ярих юм байна.

Насколько я знаю...

Миний мэдэж байгаагаар...

В сущности (говоря), по существу, по сути дела...

Үнэн хэрэг дээр, үнэндээ...

Как я слышал...

...гэж би дуулсан.

Если я Вас правильно понял...

Хэрвээ би зөв ойлгосон бол...

Надеюсь...

...найдаж байна.

Я хотел бы отметить, подчеркнуть...

...онцлон тэмдэглэх гэсэн.

### Одобрение. Согласие

Я разделяю (полностью) Ваше мнение.

Миний санал нийцэж байна.

Я придерживаюсь той же точки зрения.	Би санал нэгтэй.
Я согласен с Вами.	Би зөвшөөрч байна.
Я согласен с Вами за исключением...	Уг нь би зөвшөөрч байна, гэвч...
Я хотел бы присоединиться к Вашей точке зрения.	Таны саналд нийлэх юмсан.
Я могу к этому только присоединиться.	Үнэн, татгалзах юм байхгүй.
С этим можно только согласиться.	Ярих юм байхгүй.
Я тоже так считаю.	Мөн би тэгж бодож байна.
Вы совершенно правы.	Маш зөв.
Вот именно!	Яг үнэн!
Так оно и есть!	Зүйтэй!
Против этого не возражишь.	Тэгэлгүй яах вэ?

### Сомнение

У меня есть некоторые сомнения.	Надад эргэлзэх юм байна..
Это не совсем так.	Тийм ч биш юм.
Возможно это и так, но следовало бы все же принять во внимание то, что...	Тийм ч тийм гэвч анхаарууштай зүйл бас байна.
Мне кажется это сомнительным.	Эргэлзээтэй асуудал гэж би бодож байна.
Я не совсем уверен.	Үнэмшмээргүй юм.
Это правильно, но...	Зөв л байна гэвч...

Разрешите мне все же  
усомниться.

Эргэлзмээр юм.

### Предположение

Я предполагаю, что...	...гэж би бодож байна.
Предположим...	...гэж бодъё.
Я хотел бы думать, что...	...гэж бодмоор.
Я сказал бы...	хэлэх гэсэн гэмээр хэлмээр
Возможно	Магадгүй
Вероятно	Тийм байхаа
Очевидно	Тийм бололтой

### Возражение. Несогласие

Сожалею, но я вынужден Вам возразить.	Уучлаарай, би Таныг зөвшөөрч чадахгүй.
Я не согласен с Вашей точкой зрения.	Таны санал нийцэхгүй.
Я совершенно другого мнения.	Миний санал шал өөр байна.
Я считаю это мнение неправ- вильным.	Би Таны саналыг буруу гэж үзэж байна.
Я категорически возражаю.	Би татгалзаж байна.
К сожалению, я не могу с этим согласиться.	Харамсалтай нь би үүнийг зөвшөөрч чадахгүй.
Это не так.	Тийм биш.
Вы неправы.	Таны буруу.
Вы ошибаетесь (заблуж- даетесь).	Та ташаарч байна.

